



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО




# БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТ (CORPORATE) ХЭРЭГЛЭГЧИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА


## Тайлан:

Мэдээлэл Холбооны чадавхийн Хөгжлийн Форум

Огноо: 2024.08.23







## Нэг. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Энэ бүлэгт судалгааны зорилго, зорилт, аргазүй болон мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын үе шатын талаар дэлгэрэнгүй тайлбарлана.

### 1.1. Судалгааны зорилго

Энэхүү судалгаа нь аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй харилцаа холбоо, интернэт үйлчилгээний нөхцөл байдал, хүртээмж, эрэлт хэрэгцээ, тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлж, зохицуулалтын санал боловсруулах зорилготой.

Судалгааны ерөнхий зорилгод хүрэхийн тулд интернэт хэрэглэгч (байгууллага, бизнесийн) болон үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулан тус үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал болон хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, дүгнэх ба дүгнэлтийн хүрээнд тулгамдаж буй асуудал болон нөхцөл байдлыг нарийвчлан судлан цаашид энэ асуудлыг шийдвэрлэх боломж нөхцөлийг тодорхойлно.


#### *Хүснэгт 1. ХХЗХ-оос ирүүлсэн ажлын даалгаврын үндэслэл*

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2025 он хүртэлх дунд хугацааны стратеги зорилгуудыг “Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах тэгш, хүртээмжтэй харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ”, “Харилцаа холбооны салбарт өрсөлдөөн, инновацийг дэмжин, хөгжлийг эрчимжүүлж, цахим үйлчилгээ хөгжих орчин болон харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тодорхойлсон.

Зохицуулах хорооноос олгосон харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар суурин интернэтийн үйлчилгээ эрхэлж буй 61 тусгай зөвшөөрөл эзэмшигч (ISP) байгаагаас 27 нь Монгол Улс, 16 нь Улаанбаатар, 18 нь аймаг сумын хамрах хүрээ бүхий тусгай зөвшөөрөлтэй байна. Нийт 61 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 47 нь идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж, нийт 498,889 хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байгаагаас 471,729 нь өрх, 23,217 нь аж ахуйн нэгж, 3,946 нь төсвийн байгууллага байна.

2023 онд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн шалгалтын үр дүнгээр 34 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 22 тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвхөн байгууллагын хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байна. Тэдгээрээс өөрийн групп компанийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг 5, 5 хүртэл тооны байгууллагад үйлчилдэг 5, 1 байгууллагад үйлчилдэг 2 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

Цахим үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, дижитал шилжилт, дижитал эдийн засгийг дэмжихэд төрийн болон бизнесийн бүх төрлийн байгууллагуудын интернэт холболт, хэрэглээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний боломж нөхцөл уян хатан байх нь чухал юм.



Иймд аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй интернэт үйлчилгээний нөхцөл байдал, байгууллагын онцлогоос хамаарсан хэрэгцээ шаардлагыг дэлгэрүүлэн судалж, аж ахуйн нэгж байгууллагууд, бизнес эрхлэгчдэд интернэт үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, үйлчилгээ авах нөхцөл бололцоог сайжруулах, саадыг бууруулах, үр ашигтай өрсөлдөөн, инновацыг дэмжих, интернэтийн хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалтын арга замыг тодорхойлох хэрэгцээ шаардлага байна.

Судалгааны хүрээнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй харилцаа холбоо, интернэт үйлчилгээний нөхцөл байдал, онцлог, хүртээмж, эрэлт хэрэгцээг тодорхойлох
2. Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс аж ахуйн нэгж, байгууллагад интернэтийн үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлох
3. Интернэтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлага, чиг хандлагын талаар олон улсын зохицуулалтын туршлага судлах, харьцуулсан дүн шинжилгээ хийх
4. Интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, тавигдах нөхцөл шаардлагын талаар Зохицуулалтын санал боловсруулах


## 1.2. Судалгааны зорилт

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллалаа. Үүнд:

- ◆ Интернэт хэрэглэгчийн (байгууллагын) өнөөдрийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлагыг судлах, тодорхойлох.
- ◆ Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, түүнийг хангаж буй түвшин, үйлчилгээ эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, дэлгэрэнгүй мэдээллээр хангах.
- ◆ Үйлчилгээ үзүүлэгч байгууллага (ISP) болон үйлчилгээний төрлүүдийг нарийвчлан тодорхойлж, хэрэглэгч болон үйлчилгээ эрхлэгчдийн хооронд ямар төрлийн хэрэгцээ үүсэж буй болон үүнд үзүүлэх зохицуулалтын асуудлаар санал зөвлөмж боловсруулах.

## 1.3. Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн оролцоог харуулсан асуудлыг судлах зорилгоор зохиомжийн үндсэн элементүүд болох эх олонлог, хамрах хүрээ, түүвэрлэлтийн нэгж, түүврийн үе шат болон бүлэглэл, түүврийн хэмжээ болон түүний хуваарилалт, түүврийн хүрээ болон анхан шатны нэгжийн сонголт зэргийг захиалагчтай ярилцан тохиролцож сонгосон бөгөөд зорилтод нийцсэн хариулт, мэдээллийг тодруулах хүрээнд хамрах хүрээг тогтоон судалгааг зохион байгуулсан.



### 1.3.1. Судалгааны эх олонлог, хамрах хүрээ, түүвэрлэлтийн нэгж

Судалгааны эх олонлог:	Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд; Интернэтийн үйлчилгээ авч буй аж ахуйн нэгж байгууллагууд;
Түүвэрлэлтийн нэгж:	Аж ахуйн нэгж байгууллага;

### 1.3.2. Түүврийн зохиомж, агуулга

Судалгааны үр дүнд тооцогдох үндсэн үзүүлэлтүүдийг статистикийн хувьд бодитой байдлаар энгийн тулгах арга ашиглан гүйцэтгэв. Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын мэдээлэл болон үйлчилгээ авч буй хэрэглэгчийн асуулгад хариулсан хариулт болон статистик тоон мэдээлэлд үндэслэн өнөөгийн нөхцөл байдал болон зохицуулалтын агуулгыг үнэлэх, баримт бичигт үнлэгээ дүгнэлт хийх олон улсын харьцуулалт судалгааг гүйцэтгэсэн.

### 1.4. Судалгааны тайлан боловсруулах аргачлал, бүрэлдэхүүн


Судалгааны тайланг ажлын даалгаварын ерөнхий дарааллын хүрээнд гүйцэтгэсэн ба зураг дүрслэлийг оруулан утга санааг илэрхийлэн, шаардлагатай зарим харьцуулалтуудыг хийж тайланд тусгалаа.

Тайлангийн бүрэлдэхүүн:

- ◆ Судалгааны тайлан
- ◆ Асуулгын хуудас
- ◆ Хариулт дата
- ◆ Нэгтгэсэн хүснэгтүүд
- ◆ Фокус ярилцлага
- ◆ Транскрипт (Word)

### Судалгааны аргачлал

№	Зорилт	Аргачлал
1	Аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй харилцаа холбоо, интернэт үйлчилгээний нөхцөл байдал, онцлог, хүртээмж, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Өнөөгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах Аж ахуйн нэгж байгууллагуудаас судалгаа авах <ul style="list-style-type: none"><li>- Тоон судалгаа буюу асуулгаар</li><li>- Чанарын судалгаа буюу ярилцлагын аргаар</li></ul>
2	Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс аж ахуйн нэгж,	Статистик тайлан, шалгалтын мэдээлэлд үндэслэж, интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгууллагын үйлчилгээний талаарх тоон мэдээллийг цуглуулах




	байгууллагад интернэтийн үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлох	Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс судалгаа авах - Тоон судалгаа буюу асуулгаар - Чанарын судалгаа буюу ярилцлагын аргаар
3	Интернэтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлага, чиг хандлагын талаар олон улсын зохицуулалтын туршлага судлах, харьцуулсан ДҮН шинжилгээ хийх	Нэр бүхий улсуудын интернэт үйлчилгээний тусгай зөвшөөрөл, тавьж буй шаардлага, чиг хандлагын талаар харьцуулсан судалгаа хийж мэдээлэл цуглуулах  Зохицуулалтын чиг хандлага, ХХЗХ-ны алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудад нийцэх интернэт үйлчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлох хүрээнд тусгай зөвшөөрөл, нөхцөл шаардлагатай холбоотой зохицуулалтын хувилбар санал дэвшүүлэх
4	Интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, тавигдах нөхцөл шаардлагын талаар санал дэвшүүлэх	Дээрх зорилтуудын хүрээнд цуглуулсан мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн интернэт үйлчилгээний зохицуулалтын чиглэл, тусгай зөвшөөрөл, нөхцөл шаардлагыг шинэчлэх санал боловсруулах

#### 1.5. Судалгааны төлөвлөлт, гүйцэтгэл

№	Зорилт	Аргачлал, гүйцэтгэл	Хугацаа
1	Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс аж ахуйн нэгж, байгууллагад	ХХЗХ-ны статистик тайлан, зах зээлийн мэдээлэлд үндэслэж, интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэрэглэгчийн ерөнхий мэдээллийг нэгтгэн боловсруулсан.	6/21 – 7/22
2	интернэтийн үйлчилгээ үзүүлэхэд	Судалгааны асуулга боловсруулах, захиалагчаар хянуулан, туршилт хийсэн.	7/15
3	тулгамдаж байгаа асуудлуудыг	Интернэтийн ТЗЭ-дээс судалгааг авах ажил зохион байгуулсан.	7/22 – 8/02
4	тодорхойлох	Судалгааны дүнг нэгтгэн боловсруулан, дүгнэлт хийсэн.	8/05 –8/15
5	Аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй харилцаа холбоо, интернэт	Нийт ААН байгууллагын талаар өмнө хийгдсэн тооллого, судалгаа, мэдээллийг цуглуулж, нийт тоог төрөл, ангиллаар гарган зах зээлийн нөхцөл байдалд дүгнэлт хийсэн.	7/05





6	үйлчилгээний нөхцөл байдал, онцлог, хүртээмж, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Судалгаанд хамруулах байгууллагуудыг тодорхойлох, хугацааны хуваарь гарган судалгааг эхлүүлсэн.	8/05
7		Судалгааны асуулга боловсруулах, захиалагчаар хянуулах, туршилт судалгаа хийсэн.	7/22-7/30
8		Аж ахуйн нэгж байгууллагуудаас судалгаа авах, ярилцлага зохион байгуулах ажил хийсэн.	8/05 – 8/10
9		Аж ахуйн нэгж байгууллагаас авсан судалгааны дүнг нэгтгэн боловсруулах, дүгнэлт хийсэн.	8/10 –8/21
10	Интернэтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлага, чиг хандлагын талаар олон улсын зохицуулалтын туршлага судлах, харьцуулсан дүн шинжилгээ хийх	Олон улсад интернэт үйлчилгээний тусгай зөвшөөрөл, тавьж буй шаардлага, чиг хандлагыг судалсан.	7-р сар
		Зохицуулалтын чиг хандлага, ХХЗХ-ны алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудад нийцэх интернэт үйлчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлж, одоогийн хэрэгжиж буй тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагатай харьцуулж, давуу сул талыг шинжилсэн.	8-р сар
11	Интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, Н/Ш Зохицуулалтын санал боловсруулах	Дээрхи зорилтуудын хүрээнд цуглуулсан мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн интернэт үйлчилгээний зохицуулалтын чиглэл, тусгай зөвшөөрөл, нөхцөл шаардлагыг шинэчлэх санал боловсруулан дуусгаад байна.	8-р сар





## Хоёр. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын хэмжээнд суурин интернэтийн үйлчилгээ эрхэлж буй 54 тусгай зөвшөөрөл эзэмшигч (ISP) байгууллагуудаас судалгаанд 30 тусгай зөвшөөрөл эзэмшигч идэвхтэй хамрагдсан бөгөөд түүврийн аргачлал болон цуглуулсан мэдээлэлд үндэслэн зах зээлийг бүрэн хамарсан гэсэн дүгнэлтийг гаргасан.

Үйлчилгээ эрхлэгчдийн хамрах хүрээний хувьд:

- Монгол Улсын хэмжээнд – 27
- Улаанбаатар хотод - 16
- Аймаг суманд - 18 байна.


Идэвхтэй гэрээт хэрэглэгчийн тоогоор зах зээлд эзлэх хувийг нийт Монгол Улс, Улаанбаатар хот болон орон нутагт гэж тооцвол ТОП 6 компани нийт зах зээлийн 99 орчим хувийг эзэлж байна.

*Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь,  
идэвхтэй хэрэглэгчийн тоогоор,*


№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	384,027	76.98%	293,881	77.48%	90,146	75.39%
2	Скаймедиа корпораци ХХК	53,573	10.74%	46,080	12.15%	7,493	6.27%
3	Мобинет ХХК	24,308	4.87%	15,302	4.03%	9,006	7.53%
4	Эн Би Си ХХК	9,530	1.91%	8,780	2.31%	750	0.63%
5	Монголын цахилгаан холбоо ХК	16,210	3.25%	5,901	1.56%	10,309	8.62%
6	Кевико ХХК	7,548	1.51%	7,320	1.93%	228	0.19%
	Нийт		<b>99.3%</b>		<b>99.5%</b>		<b>98.6%</b>

\*Эх сурвалж: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ:

Суурин интернэт үйлчилгээний орлого 2023 онд өмнөх оноос 15.18 хувиар өсөж 198.6 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт орлогын 54.3 хувь нь өрх, 6.1 хувь нь төсвийн байгууллага, 37.5 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчээс бүрдүүлж байна.



### Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц




\*Эх сурвалж: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ:

Монгол Улсын хэмжээнд суурин интернэтэд холбогдсон буюу гэрээт хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 62,442 -оор нэмэгдэн 498,889-д хүрч өмнөх оноос 14.3 хувиар өсжээ.

Үүний 471,729 нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд нийт өрхийн 48% нь суурин интернэтэд холбогдсон нь өмнөх оноос 3.2 хувиар өсжээ. 100 хүнд ногдох үзүүлэлтээр тооцвол 14.2 хувьд хүрсэн байна.


### Суурин интернэт хэрэглэгчийн тоо



\*Эх сурвалж: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ:

Суурин интернэт хэрэглэгчийг байршлаар нь авч үзвэл 76.03 хувь нь Улаанбаатар хотод, 23.97 хувь нь орон нутагт байна.

Нийт өрхийн тоотой харьцуулбал Улаанбаатар хотод суурин интернэтийн нэвтрэлт 81.56 хувь, харин орон нутагт 23.06 хувьтай байна.




### Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар



\*Эх сурвалж: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ:

Суурин интернэт хэрэглэгчийн 96.1 хувь нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ, үлдсэн 3.9 хувь нь Wi-Fi, Wi-MAX, DSL -ийн холболттой байна. 2020 онд гэрээт интернэт хэрэглэгчийн тоо буурсан бол 2021, 2022, 2023 онуудад өсч, шилэн кабелиар холбогдсон хэрэглэгчийн тоо 2023 онд 15.7 хувиар нэмэгджээ.


### Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр



\*Эх сурвалж: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ:

Интернэт хэрэглээ өсөхийн хэрээр гэрээт хурд өсөж байна. 2023 оны тоон мэдээллээр нийт хэрэглэгчийн 86.9 хувь нь 10 Мбит/сек-ээс дээш хурдаар үйлчилгээ авч байна.

### Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар




\*Эх сурвалж: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 ОНЫ СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ:

Нийт интернэтийн хэрэглэгчийн 94.6 хувь нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд өрхийн тоотой харьцуулбал нэвтрэлт 47.9 хувь, Улаанбаатар хотод 77.2 хувь, аймгуудаас хамгийн өндөр нь Орхон аймаг 67.7 хувьтай, харин хамгийн бага нь Завхан аймаг 7.6 хувьтай байна.

### Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр

Аймаг, хот	Хэрэглэгчийн тоо			Өрхийн тоо*	Өрхийн нэвтрэлт
	Нийт	Байгууллагын	Өрхийн		
<b>НИЙТ</b>	<b>498,889</b>	<b>27,160</b>	<b>471,729</b>	<b>983,485</b>	<b>47.97%</b>
<b>УЛААНБААТАР</b>	<b>379,317</b>	<b>20,247</b>	<b>359,070</b>	<b>465,059</b>	<b>77.21%</b>
<b>БАРУУН БҮС</b>	<b>16,123</b>	<b>1,204</b>	<b>14,919</b>	<b>111,637</b>	<b>13.36%</b>
БАЯН-ӨЛГИЙ	2,811	251	2,560	26,329	9.72%
ГОВЬ-АЛТАЙ	3,082	200	2,882	16,430	17.54%
ЗАВХАН	1,856	205	1,651	21,710	7.60%
УВС	3,646	262	3,384	22,950	14.75%
ХОВД	4,728	286	4,442	24,218	18.34%
<b>ХАНГАЙН БҮС</b>	<b>41,423</b>	<b>2,020</b>	<b>39,403</b>	<b>179,321</b>	<b>21.97%</b>
АРХАНГАЙ	3,046	197	2,849	28,257	10.08%
БАЯНХОНГОР	5,198	257	4,941	27,101	18.23%
БУЛГАН	2,129	305	1,824	19,328	9.44%
ОРХОН	21,009	690	20,319	30,005	67.72%
ӨВӨРХАНГАЙ	3,732	290	3,442	34,448	9.99%
ХӨВСГӨЛ	6,309	281	6,028	40,182	15.00%
<b>ТӨВИЙН БҮС</b>	<b>47,602</b>	<b>2,939</b>	<b>44,663</b>	<b>156,784</b>	<b>28.49%</b>
ГОВЬСҮМБЭР	2,379	129	2,250	5,390	41.74%



ДАРХАН -УУЛ	16,579	624	15,955	30,434	52.42%
ДОРНОГОВЬ	7,651	491	7,160	21,543	33.24%
ДУНДГОВЬ	1,974	164	1,810	14,875	12.17%
ӨМНӨГОВЬ	8,385	777	7,608	25,336	30.03%
СЭЛЭНГЭ	6,861	396	6,465	30,361	21.29%
ТӨВ	3,773	358	3,415	28,845	11.84%
<b>ЗҮҮН БҮС</b>	<b>14,424</b>	<b>750</b>	<b>13,674</b>	<b>70,684</b>	<b>19.35%</b>
ДОРНОД	7,955	312	7,643	25,347	30.15%
СҮХБААТАР	2,394	195	2,199	19,481	11.29%
ХЭНТИЙ	4,075	243	3,832	25,856	14.82%

\*Эх сурвалж: 2023 оны байдлаар өрхийн тоог 1212.тн

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 27,160 байгууллага интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс суурин нитернэтийн үйлчилгээ авч байгаа нь нийт суурин интернэт хэрэглэгчийн 5.44 хувийг эзэлж байна.


Байгууллагын хэрэглэгчийн тоо 2019 он хүртэл өсч, 2020 онд буурсан бол 2021 онд буцаад өсч, сүүлийн жилд 10.4 хувиар нэмэгдсэн байна.

**Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөө, оноор**

Он		2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нийт суурин интернэт хэрэглэгчийн тоо		<b>226,147</b>	<b>285,093</b>	<b>306,150</b>	<b>317,317</b>	<b>307,166</b>	<b>379,727</b>	<b>436,447</b>	<b>498,889</b>
Үүнээс	Өрхийн хэрэглэгч	207,565	266,066	285,358	293,593	287,942	356,269	411,856	471,729
	Төсвийн байгууллагын хэрэглэгч	3,087	3,591	3,623	5,807	3,966	3,639	3,837	3,946
	Аж ахуйн нэгж	15,495	15,436	17,169	17,917	15,258	19,819	20,754	23,214
<b>Нийт байгууллагын хэрэглэгч</b>		<b>18,582</b>	<b>19,027</b>	<b>20,792</b>	<b>23,724</b>	<b>19,224</b>	<b>23,458</b>	<b>24,591</b>	<b>27,160</b>
<b>Байгууллагын хэрэглэгчийн өсөлтийн хувь</b>			<b>2.4%</b>	<b>9.3%</b>	<b>14.1%</b>	<b>-19.0%</b>	<b>22.0%</b>	<b>4.8%</b>	<b>10.4%</b>

Эх сурвалж: ХХЗХ








## Гурав. МОНГОЛ УЛСЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН НЭГДСЭН ҮР ДҮН


Үндэсний статистикийн хорооноос аж ахуйн нэгжийн тооллогыг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлыг тогтоож, тэдгээрийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үүнтэй холбогдон гарах бодлого, шийдвэрт шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой 1991, 1994, 1998, 2006, 2011, 2016, 2021 онуудад нийт 7 удаа зохион байгуулсан бөгөөд хамгийн сүүлд 2021 онд тус тооллогыг гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 3.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, тооллого явагдсан оноор



ЗУРАГ 4.11. АЖ АХУЙН НЭГЖ, компьютерын хэрэглээ, дүнд эзлэх хувиар, 2021 он






ХҮСНЭГТ 3.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, бүс, төрлөөр, 2021 он

Бүс	Аж ахуйн нэгж	Төсвийн байгууллага	Төрийн бус байгууллага
<b>Бүгд</b>	<b>151 557</b>	<b>4 597</b>	<b>23 852</b>
Баруун	8 784	963	1 660
Хангайн	11 473	1 070	2 415
Төвийн	13 968	1 101	2 476
Зүүн	4 613	481	1 031
Улаанбаатар	112 719	982	16 270

ХҮСНЭГТ 3.10. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагааны чиглэлээр, 2016, 2021 он


Үйл ажиллагааны чиглэл	2016		2021		2021 2016	%
	Тоо	%	Тоо	%		
<b>Бүгд</b>	<b>118 686</b>	<b>100.0</b>	<b>180 006</b>	<b>100.0</b>	<b>151.7</b>	
Хөдөө аж ахуй	6 263	5.3	8 544	4.7	136.4	
Аж үйлдвэр	10 139	8.5	16 285	9.0	160.6	
Барилга	10 649	9.0	13 885	7.7	130.4	
Худалдаа	44 871	37.8	65 847	36.6	146.7	
Үйлчилгээ	46 764	39.4	75 445	41.9	161.3	

ЗУРАГ 4.12. АЖ АХУЙН НЭГЖИЙН АШИГЛАДАГ КОМПЬЮТЕР, УХААЛАГ БУСАД ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, төрөл, мянган нэгжээр, 2021 он



Аж ахуйн нэгжийн тооллогын дүнгээр нийт аж ахуйн нэгжийн 28.5 хувь нь мэдээ, мэдээлэл авах, илгээхдээ 24.8 хувь нь интернэт банкны үйлчилгээ болон санхүүгийн үйлчилгээнд хамрагдахдаа, 16.4 хувь нь харилцагч хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэхдээ 13.7 хувь нь имэйл авах болон илгээхдээ, 9.0 хувь нь төрийн





болон олон нийтийн байгууллагуудтай харилцахдаа, 3.8 хувь нь эд юмс, тоног төхөөрөмж удирдахдаа интернэтийг ашигладаг байна.

ЗУРАГ 4.17. АЖ АХУЙН НЭГЖИЙН ИНТЕРНЭТ АШИГЛАЛТЫН ЗОРИЛГО,  
давхардсан тоогоор, хувиар, 2021 он




Аж ахуйн нэгжийн 31.6 мянга буюу 68.6 хувь нь үйл ажиллагаандаа сүлжээ ашиглаж байна. Тэдгээрийн 25.8 мянга буюу 56.1 хувь нь интернэт, 5.8 мянга буюу 12.5 хувь нь интранэт/дотоод сүлжээ ашигладаг байна.

Нийт интернэт ашигладаг 25.8 мянган аж ахуйн нэгжийн 17.4 мянга (67.2%) нь харилцагч/хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх, 14.5 мянга (56.3%) нь имэйл авах/илгээхэд, 13.7 мянга (53.2%) нь интернэт банкны үйлчилгээнд хамрагдах, 12.6 мянга (48.8%) нь санхүүгийн бусад үйлчилгээнд хамрагдах, 10.9 мянга (42.4%) нь бараа бүтээгдэхүүний мэдээ, мэдээлэл авах, илгээх, 9.5 мянга (37.0%) нь төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах зорилгоор ашиглаж байна.

Нийт аж ахуйн нэгжээс 5 мянга буюу 10.8% нь өөрийн өгөгдлийн сантай бол 5.4 мянга (11.6%) нь өөрийн дата сервертэй байна.

Энэхүү тооллогын хүрээнд аж ахуйн нэгжүүдийн интернэт ашиглалтын зорилгыг тодруулсан ба нийт судалгаанд оролцогч интернэт ашигладаг байгууллагын 67.2 хувь нь харилцагч/ хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх зорилгоор ашигладаг бол сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөн нэмэгдэж буй онлайн хүргэлт болон эд юмс, тоног төхөөрөмж удирдах гэсэн зорилгоор 30 орчим хувь нь ашигладаг байна.




## Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТ (CORPORATE) ХЭРЭГЛЭГЧИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН.

Энэхүү бүлгээр судалгааны зорилго, зорилтод чиглэгдсэн асуулга, ярилцлагын аргаар хийгдсэн судалгааны бодит үр дүнг ерөнхий болон тодорхой бүлгүүдээр харьцуулан харуулна.

Судалгаанд тусгай зөвшөөрөл бүхий нийт оролцогчдыг хамруулсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 30 үйлчилгээ эрхлэгч судалгаанд оролцсон. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл 2027 оноос 2036 оны хооронд хүртэл хугацаагаар олгогдсон байх ба үйлчилгээ эрхлэгчдийн 51 хувь нь Монгол Улс, 23 хувь нь Улаанбаатар хот, 26 хувь нь тодорхой заагдсан аймгуудад хамрах хүрээтэй үйлчилгээ үзүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд байгууллагын интернэтийн хэрэглэгчийг ХХЗХорооны 2023 оны статистикаар 27,160 гэж зарласан ба судалгаанд оролцогчдын (2024.07 сар) ирүүлсэн судалгаа мэдээлэлд 27,389 (Улаанбаатар хот- 21,152, Орон нутаг- 6,237) хэрэглэгчтэй гэж ирүүлсэн нь хагас жилийн өсөлтөөс гадна тус судалгааг хамрах хүрээний хувьд оролцогчдын бүрэн илтгэх боломжтой гэсэн дүгнэлт хүрэв.

Судалгааны үр дүнг асуулга, судалгаа ярилцлагын дарааллаар бус асуудлыг тодруулах уялдаа холбоосоор нь дараалуулан дараах байдлаар үр дүнг танилцуулж байна.



#### 4.1. Байгууллагын интернэтийн хэрэглэгчийн мэдээлэл

Энэхүү хэсэгт үйлчилгээ эрхлэгчийн хэрэглэгч болон хамрах хүрээ, интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчээс авч буй гадаад урсгал, Кэйш серверийн мэдээлэл зэргийг нэгтгэв.

Байгууллагын хэрэглэгчийн хувьд 27,389 хэрэглэгчийн 77 хувь нь Улаанбаатар хот, 23 хувь нь орон нутгийн гэсэн ангилалд байна.

Үйлчилгээ эрхлэгчдийн хувьд зах зээлийн төвлөрөл өндөр буюу нийт хэрэглэгчийн 51 хувь нь 1 үйлчлэгч, 46 хувь нь 4 үйлчлэгч, 3 хувь нь 20 үйлчлэгчид хуваарилагдсан байна. Хамрах хүрээний хувьд Монгол Улсын хамрах хүрээтэй үйлчилгээ эрхлэгчид 99.25 хувь буюу 26,377 хэрэглэгчтэй байгаа бол Улаанбаатар хотод хамрах хүрээтэй үйлчилгээ эрхлэгчид 0.22 хувь буюу 58 хэрэглэгчтэй, орон нутагт үйлчилгээ эрхлэх хамрах хүрээтэй үйлчилгээ эрхлэгчдийн хувьд 0.54 хувь буюу 141 хэрэглэгчтэй байна.


##### 4.1.1. Үндсэн болон нэмэлт үйлчилгээний талаарх мэдээлэл, судалгаа

Хэрэглэгчийн төрөл болон хэрэглээний талаарх (гэрээт хурд, Mbps) мэдээллийг судалгаанд оролцогчдоос авсан бөгөөд идэвхтэй үйлчилгээ үзүүлж буй нийт үйлчилгээ эрхлэгчдийн хувьд нийт хэрэглэгчийн 67 хувь нь Улаанбаатар хотын, 23 хувь нь орон нутгийн хэрэглэгч гэж бүртгэгдсэн байх бөгөөд тэдэнд гэрээлсэн нийт урсгалын хэмжээ нь 431,676 Mbps бол үүний Улаанбаатар хотын хувь хэмжээ нь 79 хувь, орон нутгийн хувь хэмжээ нь 21 хувь байна.

*Байгууллагын интернэт хэрэглэгчийн тоо, төрлөөр нийт урсгал:*

УБ хотын хэрэглэгчийн төрөл	Хэрэглэгчийн тоо	Гэрээт хурдны хэмжээ нийт (Mbps)
Бизнесийн байгууллага	18,774	289,359
Төрийн байгууллага	1,722	39,665
Төрийн бус байгууллага	433	8,173
Бусад	223	1,786
<b>Орон нутгийн хэрэглэгчийн төрөл</b>	<b>Хэрэглэгчийн тоо</b>	<b>Гэрээт хурдны хэмжээ нийт (Mbps)</b>
Бизнесийн байгууллага	3,768	60,483
Төрийн байгууллага	2,350	31,055
Төрийн бус байгууллага	82	1,091
Бусад	37	65

Нийт хэрэглэгчийн 82 хувь нь бизнесийн, 15 хувь нь төрийн, 2 хувь нь төрийн бус, үлдсэн 1 хувь нь бусад гэсэн ангиллаар хэрэглэгч болсон байна.




#### 4.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгууллагын хэрэглэгч болон хамрах хүрээ

Судалгааны явцад интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын бөөний үйлчилгээ эрхлэгчээс авч буй урсгалын хэмжээ болон байгууллагын хэрэглэгчийн хооронд хамаарлыг тодруулах зорилгоор судлаж үзвэл байгууллагын хэрэглэгчийн тоо болон урсгалын хэмжээнд хамаарал нь өрхийн хэрэглэгчтэй хамааралтай байгаа бөгөөд өрхийн хэрэглэгчгүй үйлчилгээ эрхлэгчдийн хувьд хэрэглэгч болон урсгалын хэмжээ шууд хамааралтай байна.


Энэ тооцоолол нь тухайн сүлжээний баримт бичигт заагдсан зохицуулалтаас үүдэлтэй хэдий ч хэрэглэгчийн төрөл, урсгал хоёр шууд хамааралтайг нотлож байна. ХХЗХ-ны 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 143 тоот тогтоолын хавсралтаар баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад “5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн гэрээлсэн хурдны хэмжээ оргил ачааллын цагаар хамгийн багадаа 75 хувиас багагүй байхаар ачааллын хэмжээг тооцоолж, зохион байгуулна. Үйлчилгээний чанарт байнгын хяналт тавих боломжоор Зохицуулах хороог хангана.” гэж заасан.

Байгууллагын интернэт хэрэглэгчийн тоо, тухайн үйлчилгээ эрхлэгчийн нэг хэрэглэгчид ногдож буй бөөний урсгалын хэмжээ:




Энэхүү мэдээлэл дээр зарим үйлчилгээ эрхлэгчийн хувьд цөөхөн хэрэглэгчтэй тул авч буй урсгалын хэмжээний нэгж хэрэглэгчид хуваарилагдах хурд өндөр гарсан ба ярилцлагын явцад дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

1. Байгууллагын хэрэглэгч хэдий цөөн ч өрхийн хэрэглэгч их.
2. Өрхийн хэрэглэгчгүй хэдий ч эцсийн хэрэглэгч нь томоохон групп компани болон өндөр хэрэглээтэй хэрэглэгч байх тохиолдолд гэрээний нөхцлөөр өндөр байна.




Нэгж хэргэлэгчид ногдож буй гадаад урсгалын хэмжээнд ийм савлагаа үүсэх нь дээрх шалтгаантай шууд холбоотой боловч ачааллын менежментийг сүлжээний түвшинд зохион байгуулсан үйлчилгээ эрхлэгчдийн хувьд энэхүү гадаад урсгалын хэмжээг багасгах боломжууд байна. Үүнд интернэтийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт үйлчилгээнүүдийг оруулж тооцох ёстой. Гэхдээ нийт судалгаанд оролцогчдын нэгж хэрэглэгчид ногдох гадаад урсгалын дундаж 11Mbps гэсэн үзүүлэлт гарч байна (Өндөр дүнг хасаж тооцсон).

Асуулга, судалгааны хүрээнд байгууллагын интернэт хэрэглэгчийн гэрээт урсгалын хэмжээгээр 2-5 mbps, 10 mbps, 20-30mbps, 50 mbps, 100 mbps, 300 mbps, 1000mbps гэсэн хэрэглэгч төвлөрсөн багцууд үүссэн байна. 1000Mbps болон түүнээс дээш гэрээт хурд бүхий хэрэглэгч нийт хэрэглэгчийн 0.72 хувийг эзлэж байгаа бол 300Mbps хурдаар гэрээ байгуулсан хэрэглэгч 0.29 хувийг эзлэж байна.



Зах зээлд хамгийн түгээмэл буюу олон хэрэглэгч бүхий бүлэг нь 30Mbps гэсэн тоон үзүүлэлт байна.





#### **4.1.3. Интернетийн үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний бүтэц зохион байгуулалттай холбоотой асуулга.**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн сүлжээнд кэйш сервэртэй эсэх ямар зориулалтаар хэдий хэмжээний ачаалалтай ашиглаж буй талаар, мөн байгууллагын хэрэглэгчид санал болгож буй нэмэлт үйлчилгээний мэдээллийг тодруулсан.


Нийт судалгаанд оролцогчдын 30 орчим хувь нь өөрийн сүлжээнд кэйш сервэртэй ба интернетийн ачааллыг бууруулах зорилгоор ашиглаж байгаа бөгөөд үүний 80 орчим хувь нь өөрийн сүлжээнд физик байдлаар зохион байгуулагдсан байна. Facebook, Google, Akamai, Microsoft зэрэг сервэрүүд үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээнд байршсан байна. Ачааллын хувьд Facebook, Google-ийн ачаалал харьцангуй өндөр (эцсийн хэрэглэгчийн масстай шууд хамааралтай ба байгууллагын хэрэглэгчтэй шууд хамааралгүй байдаг ярилцлагын үед тодорсон.) гэсэн дүгнэлтэд хүрсэн. Харин байгууллагын хэрэглэгчийн хувьд Microsoft зэрэг албан хэрэгцээний сервэрүүд чухал үүрэгтэй байдаг байна.

#### **4.1.4. Байгууллагын хэрэглэгчид санал болгож буй үйлчилгээний мэдээлэл. (Бусад үйлчилгээг нэмэхдээ өөр тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлдэг үйлчилгээг оруулахгүй.)**

Судалгаанд оролцогч үйлчилгээ эрхлэгчдийн 80 хувь нь хэрэглэгчиддээ Зохицуулалттай интернет (managed internet), Дотоод сүлжээ (Wi-Fi зохион байгуулах гм), Дата төвд сервер байршуулах, сервер түрээслэх, хостинг зэрэг үйлчилгээг хүрэгдэг байна. Энэ нь үйлчилгээний таатай нөхцөл бүрдүүлэх, хэрэглэгчдэд хэрэглээний таатай боломжийг нэмэгдүүлэх зорилготой байна. Эдгээр 3 үйлчилгээ нь интернет хэрэглэгчдийн хувьд үндсэн үйлчилгээтэй адилаар зах зээлд нэвтэрсэн байна.

Нийт үйлчилгээ эрхлэгчдийн хувьд хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээндээ нэмэлт нөхцөл өгөх гэхээс илүү өөрийн сүлжээний бодит боломжийг нэмэгдүүлэхэд анхаардаг бөгөөд энэ нь хэрэглэгчдэд таатай нөхцөл болдог гэж тодорхойлсон.

Зах зээлд шинээр нэвтэрсэн болон одоо үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ эрхлэгчдийн хооронд энэхүү нөхцөл нь харилцан адилгүй байх бөгөөд хэрэглэгчдэд тухайлан энэ нөхцлүүдийг тооцоолон сонголтлоо хийх боломж нь хомс байдаг гэж үзсэн.



*Байгууллагын интернэт хэрэглэгчид өгч буй нэмэлт үйлчилгээ:*

**Тав. БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ХЭРЭГЛЭГЧИЙН СУДАЛГАА.**

Интернэтийн үйлчилгээ эрхлэгчээс үйлчилгээ авдаг байгууллагуудаас түүвэрлэн авсан “Байгууллагын интернэтийн хэрэглээ хандлагын талаарх” санал асуулгын нэгтгэлээр дараах үр дүн гарав.

***A1. Үйлчилгээ эрхлэгчийн үндсэн мэдээлэл: Үйл ажиллагааны чиглэл?***

Санал асуулгад оролцсон байгууллагуудаас Боловсрол-2, Эрүүл мэнд-1, Аялал жуучлал-1, Мэдээллийн технологи-2, Орон сууц түрээс санхүүгийн үйлчилгээ-1, ОУ-ын тээвэр зуучлал-1 үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамрагдав.

№	Үйл ажиллагааны чиглэл	Нийт
1	Аялал жуучлал	1
2	Боловсрол	2
3	Эрүүл мэнд	1
4	Орон сууц түрээс, санхүүгийн үйлчилгээ	1
5	Мэдээллийн технологи, ИТ	2
6	ОУ-ын тээвэр зууч	1

***A2. Байгууллагын ажилчдын тоо?***


Байгууллагын интернэт хэрэглэгч байгууллагуудын ажилчдын тооны хувьд ИТ, мэдээлэл технологийн байгууллагууд 10-15 ажилчидтай, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч 40-50, Орон сууц түрээс, санхүүгийн үйлчилгээ 21-23, ОУ-ын тээвэр зуучлал-30, Боловсролын салбар 230-500 орчим ажилчидтай байгууллагууд санал асуулгад хамрагджээ.

№	Ажилчид	Нийт
1	20-аас доош ажилчидтай	2
2	21-30	2
3	31-50	2
4	230	1
5	500	1

***A3. Байгууллага дээрх интернэтийн гол хэрэглээ юу вэ?***

Байгууллага дээрх интернэтийн гол хэрэглээ 100% оффис хэрэглээгээ бүрдүүлэхээс гадна хэрэглэгчийн үйлчилгээ, камер хяналт, дотоод дэд бүтцэд хавсран хэрэглэдэг хэрэглээ дийлэнх хувийг бүрдүүлж байна. Байгууллагын үйл ажиллагааны төрлөөс хамаарч байгууллагын интернэт хэрэглээний үзүүлэлт харилцан адилгүй байна. Дийлэнх байгууллагууд 3-4 интернэтийн хэрэглээг хамтад нь ашиглаж байна.





1. Оффис хэрэглээ	2. Хэрэглэгчийн үйлчилгээнд	3. Камер дохиолол Хяналт	4. Өөрийн дэд бүтэц, дотоод программ	5. Бусад	Нийт тоон үзүүлэлт
Тийм	-	-	-	-	1
Тийм	Тийм	Тийм	Тийм	-	4
Тийм	-	Тийм	Тийм	-	3
Тийм	Тийм	Тийм	Тийм	-	4
Тийм	Тийм	Тийм	-	-	3
Тийм	Тийм	-	Тийм	-	3
Тийм	Тийм	Тийм	Тийм	-	4
Тийм	-	Тийм	Тийм	-	3
<b>8</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>-</b>	


**A4, A5: Интернэт үйлчилгээ авч эхлээд хэдэн жил болж байгаа вэ? Хэдэн жил тус үйлчилгээ эрхлэгчээс үйлчилгээ авч байгаа вэ?**

Санал асуулгад оролцсон хэрэглэгчдийн хувьд хамгийн урт хугацаанд хэрэглэж буй хэрэглэгч нь 23 жил хэрэглэж байсан бол хамгийн бага нь 2 жил хэрэглэж байсан, дунджаар 11 жил хэрэглэсэн хэрэглэгчид байсан. Шинээр хэрэглэгч болсон хэрэглэгчдийн хувьд интернэтийн үйлчилгээ авч буй нь үйлчилгээ эрхлэгчээ солихоор яригдаж, төлөвлөж байгаа бол 10 жил, 14 жил хэрэглэж буй нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагаа солихоор судалж байгаа гэсэн хариултууд өгсөн.

**A6, A7: Ямар ISP компаниас интернэтийн үйлчилгээ авдаг вэ? Үйлчилгээ эрхлэгчийг сонгох болсон шалтгаан, гол хүчин зүйл?**

Байгууллагуудын хувьд интернэтийн үйлчилгээ эрхлэгчийг сонгох шалтгаан, хүчин зүйлсэд интернэтийн хурд, үнэ тариф нөлөөлдөг бол нөгөө талаас анх сонгож үйлчлүүлсэн байгууллагаа солиогүй, урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд үйлчилгээ авч буй юм. Нэг тохиолдолд аялал жуулчлалын компанийн хувьд үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж байршил ойрхон шалтгаанаар интернэтийн үйлчилгээ эрхлэгчийг сонгосон байгаа нь санал асуулгаар илэрсэн. МЦХ, Жинэт ХХК, Ультанэтзон ХХК-ны хэрэглэгчдийн хувьд анх сонгосноос хойш солиогүй буюу урт хугацаанд хэрэглэж байгаа, Юнивишн ХХК компанийг сонгосон хэрэглэгчдийн хувьд интернэтийн хурд, үнэ нь сонгох хүчин зүйл болжээ. МЦХ ХК -ийн хувьд байршилд ойр гэдэг нь хэрэглэгч сонгох шалтгаан, хүчин зүйлс нь болсон байна.

6. Ямар ISP компаниас интернэтийн үйлчилгээ авдаг вэ?	7. Үйлчилгээ эрхлэгчийг сонгох болсон шалтгаан, гол хүчин зүйл
	Хамтын ажиллагааны хүрээнд
	Байршил ойрхон. Налайхад байдаг
	Интернэт нь хурдан, дата хэрэглээ нь сонгох хүчин зүйл болсон.
	Тухайн үедээ л сонгосон.
	Анх сонгосноос хойш солиогүй. Хурдтай
	Мэдэхгүй
	Хямд үнэ өндөр хурдтай



Тухайн үедээ л анх сонгосон./Ультранэтзон/	Тухайн үедээ л сонгосоноос хойш хэрэглэж байгаа.
--	--

**A8, A9: Танай байгууллагын байршилд интернэт оруулах сүлжээний дэд бүтэц, сувагчлал бэлэн байсан уу? Сүлжээ, дэд бүтцийг байгуулахад та бүхний оролцоо байсан уу? Үйлчилгээний нөхцлөө сайжруулах арга хэмжээг хэрхэн авдаг вэ?**


Санал асуулгад оролцсон 8 байгууллагаас нийт 6-д нь тухайн интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас сүлжээний дэд бүтэц холбосон гэсэн мэдээлэлтэй, 1 байгууллага өөрсдөө сувагчлал татсан бол 3 байгууллага нь тухайн байршилд сувагчлал дэд бүтцийн талаар мэдээлэл байхгүй байна.

8. Танай байгууллагын байршилд интернэт оруулах сүлжээний дэд бүтэц, сувагчлал бэлэн байсан уу? Сүлжээ, дэд бүтцийг байгуулахад та бүхний оролцоо байсан уу?	9. Үйлчилгээний нөхцлөө сайжруулах арга хэмжээг хэрхэн авдаг вэ?
Тавиулсан	Солих бодолтой
Үйлчилгээ үзүүлэгч компаниас өөрсдөө ирж хийж өгсөн.	Байхгүй
Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас өөрсдөө ирж тавьж өгсөн.	IT хэлтэс нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбогдож шийддэг.
Тухайн үедээ л сонгосон. Мэдэхгүй	Гэрээний хэрэгжилтийн дагуу, сүлжээний компанитай хамтарч ажилладаг.
Мэдэхгүй.	Интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбогдож авдаг.
Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас өөрсдөө ирж тавьж өгсөн.	Хэрэглээ хангагдаж байгаа.
5 байртай. 1 байр сувагчлалтай, 4 сувагчлал агаараар татсан. 2 жилийн өмнө өөрсдөө сувагчлал татсан.	Жил болгон багш, ажилчид оюутнуудаасаа судалгаа аваад үйлчилгээ муу байдаа үзүүлэлт дээр нь тухайн байгууллагатай зөвшилцөж сайжруулах арга хэмжээ авдаг.
Тухайн үедээ л сонгож тавьсан.	Имэйл багтаамжаа нэмэгдүүлэх талаар.

**A10: Үндсэн интернэтийн үйлчилгээнээс гадна ямар нэмэлт үйлчилгээнүүд авдаг вэ? Нэмэлт урамшууллууд байдаг уу?**

Байгууллагын интернэт үйлчилгээ дээр нэмэлтээр Call center үйлчилгээ авдаг нь аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллага байсан. Үнэ төлбөр дээр хөнгөлөлт авдаг байгууллага боловсролын салбарт хамаарах байгууллага бөгөөд үнэ тарифийн хөнгөлөлтөд тухайн байгууллага нь сэтгэл ханамжтай байгаа нь санал асуулгын явцад ажиглагдсан болно.

10. Үндсэн интернэтийн үйлчилгээнээс гадна ямар нэмэлт үйлчилгээнүүд авдаг вэ? Нэмэлт урамшууллууд байдаг уу?	Байгууллагын ирсэн саналын тоо
Нэмэлт үйлчилгээ, урамшуулал авдаггүй	5
Call center	1
Үнэ төлбөр дээр хөнгөлөлт авдаг.	1
Мэдэхгүй	1



**A11, A12: A13: Интернэтийн үйлчилгээндээ сэтгэл ханамж хэр байгаа вэ? (1-10 оноогоор үнэлбэл) та хэдэн оноо өгөх вэ? Интернэтийн үйлчилгээ эрхлэгчээ солих бодол байгаа эсэх? Хэрэв тийм бол одоо байгаа үйлчилгээнээс танд юу нь илүү таалагдсан, солих талаар бодол төрүүлсэн бэ?**


Интернэтийн үйлчилгээндээ сэтгэл ханамж хэр байгааг 1-10 оноогоор дүгнүүлэхэд дараах үр дүн гарсан. Интернэтийн үйлчилгээндээ 7-9 оноо өгсөн хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамжийн түвшин өндөр, боломжийн хэмээн дүгнэж интернэтийн үйлчилгээ эрхлэгчээ солих бодолгүй байна. Харин сэтгэл ханамжийн оноо 5-6 үзүүлэлттэй хэрэглэгчдийн хувьд интернэтийн үйлчилгээ эрхлэгчээ солих бодолтой, судалж байгаа гэсэн өгүүлэмжтэй. Интернэтийн үйлчилгээ эрхлэгчээ солих болсон шалтгаануудад интернэт гацдаг, интернэтийн хурд удаан, засвар үйлчилгээ нь уддаг зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

11. Интернэтийн үйлчилгээндээ сэтгэл ханамж хэр байгаа вэ? (1-10 оноогоор үнэлбэл) та хэдэн оноо өгөх вэ?	12. Интернэтийн үйлчилгээ эрхлэгчээ солих бодол байгаа эсэх?	13. Хэрэв тийм бол одоо байгаа үйлчилгээнээс танд юу нь илүү таалагдсан, солих талаар бодол төрүүлсэн бэ?
9 оноо	Одоохондоо байхгүй	Боломжийн
8 оноо	Солихгүй /2/	-
7 оноо	Одоохондоо байхгүй	-
6 оноо	Солихоор яригдаж байгаа, судалж байгаа	-Хурд, баруун жигүүрийн шилэн кабел гэмтэж засагдаагүй 3 сар болж байгаа. -Юнивишн, скаймедиагаар солихоор яригдаж байгаа. -Заримдаа гацаад удаан болдог.
5 оноо	Солино гэж төлөвлөж байгаа.	Гацдаг.

**A14. Танай байгууллага интернэт, дотоод сүлжээний үйлчилгээг хариуцдаг тусдаа алба хэлтэстэй эсэх?**

Санал асуулгаар интернэтийн үйлчилгээ авч буй байгууллагуудын 4 нь байгууллага дээрээ дотоод сүлжээ хариуцдаг алба хэлтэстэй, 2 нь IT мэргэжилтэнтэй, 1 нь гэрээт IT компанитай хамтарч ажилладаг. Гэрээт IT компанитайгаа шаардлагатай тохиолдолд л хамтарч ажилладаг байна.

14. Танай байгууллага интернэт, дотоод сүлжээний үйлчилгээг хариуцдаг тусдаа алба хэлтэстэй эсэх?	Байгууллагын ирсэн саналын тоо
IT хэлтэстэй	4
IT ажилтан эсвэл мэргэжилтэнтэй	2
IT хэлтэс байхгүй, гэрээт IT компанитай хамтарч ажилладаг.	1
Байхгүй	1




***А15. Интернет сүлжээнд гарсан гэмтэл саатлыг өөрсдөө шийдвэрлэдэг үү? Эсхүл байнгын тусламжийг интернэтийн үйлчилгээ эрхлэгчээсээ авдаг уу?***

Нийт санал асуулгад хамрагдсан 8 байгууллагаас дотоод сүлжээний үйлчилгээг хариуцдаг алба хэлтэстэй 4 байгууллага байдаг. Тэд гэмтэл засвар гарсан үед өөрсдийн нөөц боломжоороо асуудлаа эхэлж шийдвэрлэдэг. Өөрсдийн шийдвэрлэж чадахгүй асуудал гарсан тохиодолд үйлчилгээ эрхлэгч байгууллага руу ханддаг бол IT хэлтэсгүй байгууллага нь шууд үйлчилгээ эрхлэгч рүү ханддаг. Гэмтэл, засвар гарсан үед өөрсдөө хариуцдаг байгууллага нь үйлчилгээ эрхлэгч байгууллагын засвар, дуудлага үйлчилгээ нь удаж ирдэг учраас өөрсдөө шийдвэрлэхээс өөр аргагүй байдаг, зарим тохиодолд засвар үйлчилгээ хийгдээгүй 3 сар болж буй гэх хариултууд өгч байсан.

IT хэлтэсгүй, гэрээтээр IT байгууллагатай хамтарч ажилладаг байгууллагын хувьд шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага руугаа ханддаг байна. Дотоод сүлжээ хариуцсан хэлтэсгүй, мэргэжилтэнгүй байгууллагын хувьд шууд үйлчилгээ эрхлэгч рүү хандаж асуудлаа шийдвэрлэдэг гэв.

***А16: Интернетийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт санал, хүсэлт байгаа юу? (Санал асуулгад оролцогчдоос ирсэн нэмэлт саналуудыг дор жагсаав)***

- Дуудлага удаж ирдэг. Ажилтанууд нь их солигдож ирдэг.
- Дата хэрэглээ нь хурдан дуусдаг, удаан байдаг. Олон давхар байшингийн хувьд давхар бүрт сүлжээний хүртээмж хүрдэггүй, хангалтгүй. 4 давхар сургуулийн булангийн өрөөнүүдэд сүлжээ барьдаггүй.
- Интернетийн үйлчилгээгээ солиулъя гэсэн бодолтой судалж байгаа, солих шалгаан нь интернэтийн хурдаа сайжруулах, хурдаа нэмэгдүүлэх зорилготой зэрэг саналуудыг ирүүлжээ.



## Зургаа. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Интернэтийн үйлчилгээг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” (Зөвшөөрлийн тухай хуулийн 9.4-д заасан) тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлнэ.

Тус үйлчилгээний нөхцөл шаардлагыг хамгийн сүүлд 2024 оны 6-р сарын 27-ны өдрийн 143 тоот тогтоолоор шинэчлэн баталсан.

Нөхцөл шаардлагад тодорхойлсноор “Интернэтийн үйлчилгээ” гэж утастай, утасгүй (WiFi, mobile radio access гм) болон хиймэл дагуулын технологиор хэрэглэгчид гэрээний үндсэн дээр интернэт холболтын боломжийг бүрдүүлж, интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээг ойлгоно. Утасгүй технологи гэдэгт үүрэн холбооны 3G, 4G/LTE технологи, утасгүй сүлжээний WiFi технологи хамаарч байна.

Нөхцөл шаардлагын хүрээнд интернэт үйлчилгээний хэрэглэгчийг өрх, байгууллагаар ялган тодорхойлоогүй ба түүнд харгалзах тусдаа нөхцөл, шаардлага тавигдаагүй байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.6.-д "хэрэглэгч" гэж харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх гэрээнд үйлчилгээг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийг гэж заасан.


Интернэтийн үйлчилгээ эрхлэгчдээс тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын талаар дараах асуулгаар тодруулга авсан. Үүнд:

- 6.1. Мөрдөж ажиллахад хүндрэлтэй биш, хэрэгжүүлэхэд боломжийн.
- 6.2. Сайжруулах шаардлагатай.
- 6.3. Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй.
- 6.4. Манай эрхэлж буй үйл ажиллагаанд тохирохгүй байгаа.
- 6.5. Байгууллагын хэрэглэгчийн хувьд нэмэлт үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгохтой холбоотой зөвшөөрлийн болон зохицуулалтын баримт бичигт шаардлагатай санал байвал дурдана уу.

Нийт судалгаанд оролцогчид тус баримт бичгийг мөрдөж ажиллахад хүндрэлтэй биш, үйл ажиллагаанд тохиромжтой байгаа гэж хариулсан ба 23 хувь нь тус баримт бичгийг сайжруулах шаардлагатай гэж хариулсан байна.

Үүссэн нөхцөл байдал болон зохицуулалтын баримт бичигт тусгагдсан агуулга тус бүрээр дор дүгнэлт гаргав.






Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн  
143 тоот тогтоолын хавсралт

**“ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
НӨХЦӨЛ, ШААРДЛАГА” (ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД)**


<b>Баримт бичигт хийгдсэн ерөнхий зохицуулалт:</b>	<b>Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:</b>	<b>Судалгааны хүрээнд гарсан санал:</b>
<p>1.1.Энэхүү баримт бичгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн интернэтийн үйлчилгээ (цаашид “интернэтийн үйлчилгээ ” гэх) эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтооно.</p> <p>1.3.Интернэтийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлнэ.</p> <p>1.4.Интернэтийн үйлчилгээ гэж утастай, утасгүй болон хиймэл дагуулын технологиор хэрэглэгчид гэрээний үндсэн дээр интернэт холболтын боломжийг бүрдүүлж, интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээг ойлгоно.</p> <p>ХОЁР. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ТАВИХ НИЙТЛЭГ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА</p> <p>ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА</p> <p>ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШААРДЛАГА</p> <p>ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</p>	<p>Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай <b>зөвшөөрлийн хүрээнд</b> хэрэглэгчид гэрээний үндсэн дээр интернэт холболтын боломжийг бүрдүүлж, интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээг ойлгоно.</p> <p><b>Баримт бичигт дүн шинжилгээ хийхэд газар зүйн хүрээ болон үйлчилгээ үзүүлж буй хүрээ, агуулгаар ялган тогтоосон, нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.</b></p> <p>5.6 заалт үйлчилгээний хамрах хүрээгээр ялгасан зохицуулалт байх боловч авч хэрэгжүүлж буй зорилго чиглэл нь тодорхойгүй байна. 5.6. <i>Улаанбаатар хотод 50 Мбит/сек, аймгийн төвд 10 Мбит/сек ба түүнээс дээш гадаад интернэтийн урсгалыг түрээсэлнэ. (Сум суурин газарт дээрх нөхцөл хамаарахгүй)</i></p>	<p>Идэвхтэй үйлчилгээ эрхлэгчдийн бүртгэлд 24 үйлчилгээ эрхлэгч байгаагаас 15 нь Монгол Улсад, 4 Улаанбаатар хот, 5 нь Аймагт хамрах хүрээтэй байгаа хэдий ч Нийт хэрэглэгчийн 99.25 хувь буюу 26,377 нь Монгол Улсад хамрах хүрээтэй үйлчилгээ эрхлэгч, 0.22 хувь буюу 58 нь Улаанбаатар хотод хамрах хүрээтэй, 0.54 хувь буюу 141 хэрэглэгч нь Орон нутагт үйлчилгээ эрхлэх хамрах хүрээтэй үйлчилгээ эрхлэгчид бүртгэлтэй байна.</p> <p><b>Тусгай зөвшөөрлийн газарзүйн хамрах хүрээгээр ангилсан ангилал нь зах зээлд өндөр ач холбогдолтой зохицуулалт байхаа больсон ба хэрэглээ, технологийн түвшинд ангилах нь илүү тохиромжтой байна.</b></p> <p><b>Одоогийн ангилал нь газар зүйн хамрах хүрээний хувьд өндөр ач холбогдолгүй байна.</b></p>
<p><b>Дүгнэлт:</b> Зах зээлд үүссэн нөхцөл байдал болон үйлчилгээ эрхлэгчдийн дэд бүтэц, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, чиглэлд уялдсан зохицуулалтын агуулгыг тусгах, тодорхойлох шаардлагатай байна.</p> <p>Одоо мөрдөгдөж буй зохицуулалтын агуулга нь газар зүйн хувьд хамрах хүрээг тодорхойлж байгаа боловч түүнд уялдсан зохицуулалтын уялдаа баримт бичигт тусгагдаагүй байна.</p>		



Технологи тодорхойлсон зохицуулалт:	Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:	Судалгааны хүрээнд гарсан санал:
<p>1.4.Интернэтийн үйлчилгээ гэж утастай, утасгүй (1 Үүрэн холбооны 3G, 4G/LTE технологи, утасгүй сүлжээний WiFi технологи) болон хиймэл дагуулын технологиор хэрэглэгчид гэрээний үндсэн дээр интернэт холболтын боломжийг бүрдүүлж, интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээг ойлгоно.</p>	<p>Интернэтийн үйлчилгээг хүргэх технологийг тодорхойлсон. Технологийг сонгох боломж нь хязгаарлагдмал, зөвшөөрлийн хүрээгээр буюу анх хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдлаар сонгогддог. Баримт бичгийн хүрээнд технологийн хувьд тусгайлсан зохицуулалтууд байхгүй. Нээлттэй мэт боловч хязгаарлагдмал нөөцөөс хамааралтай. Технологи хооронд шилжих боломж хязгаарлагдмал.</p>	<p>Хэрэглэгчийн хувьд үйлчилгээг байршил болон дэд бүтэцтэй уялдуулан чөлөөтэй сонгон авч болох нөхцөл бүрдсэн мэт боловч бодит байдалд аль дэд бүтэц хүртээмжтэй этгээдээс үйлчилгээг авах бусдыг сонгох, үйлчилэгчээ солих тохиолдолд дэд бүтэцийн асуудал тулгардаг байна.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Зохицуулалтын хувьд үйлчилгээ хүргэх технологийн боломж нээлттэй хэдий ч технологи хооронд шилжих үйлчилгээг саадгүй хүргэх үед зөвшөөрлийн хамрах хүрээгээр хязгаарлагдаж байна.</p>		

Интернэт дэх үр ашгийг нэмэгдүүлэх, үр ашигтай байх зохицуулалт:	Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:	Судалгааны хүрээнд гарсан санал:
<p>2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлагын 4.2-т заасны дагуу улс хоорондын сүлжээ байгуулж, интернэтийн бөөний урсгал нийлүүлэх үйлчилгээ эрхлэх эрх бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сүлжээнд “Сүлжээ хооронд харилцан</p>	<p>Зохицуулалтын агуулгыг тодорхойлох, технологийн зохицуулалт болон эдийн засгийн агуулгыг (гадаад урсгалыг өөр өөр түвшинд боловсруулсан интернэт гэрээлэх, шууд холболтуудыг зөвшөөрөх, Улс доторх холболт/VPN/ үйлчилгээ зэрэг) тодорхой болгох шаардлагатай байна. Энэ нь баримт бичгийн хүрээнд бөөний урсгал интернэтийг тодорхойлох мэт боловч үйлчилгээний түвшинд олон төрлийн үйлчилгээнээс бүрдэж байгаа бөгөөд энэ үйлчилгээнүүд нь тусгай зөвшөөрлийн хүрээнд аль</p>	<p>Зах зээл дээр цөөн хэрэглэгчтэй хэдий ч авч буй урсгалын хэмжээ өндөртэй үйлчилгээ эрхлэгчид байгаа нь зөвхөн интернэт урсгал түрээслэх зорилготой томоохон байгууллагын хувьд гарсан бизнес загвар байх боломжтой бөгөөд эдгээр үйлчилгээ эрхлэгчдийн хувьд энэхүү нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажиллах чадвартай хэдий ч өгч буй үйлчилгээний хувьд дийлэнх нь зөвхөн урсгалын үйлчилгээ байна.</p>






<p>холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам"-ын дагуу холбогдож, интернэтийн урсгал түрээслэнэ.</p>	<p>бизнесийн аль тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд байх нь тодорхойгүй, давхардсан байна.</p> <p><i>“Боловсруулсан интернэт” буюу өөрийн сүлжээнд нийлүүлж буй нөөцөлсөн болон өөрийн мэдлийн контент нийлүүлэлт, вэб хост зэрэг үйлчилгээнүүдийн нэгдэл.</i></p>	<p>Мөн бөөний үйлчилгээ эрхлэгчээс нөөцөлсөн урсгал тусдаа гэрээлдэг, интернэтийн шууд холболтуудыг мөн гэрээлсэн тохиолдлууд байна.</p>
--	---	--


**Дүгнэлт:** Бөөний үйлчилгээ эрхлэгч нь гадаад урсгалаас гадна нэмэлт үйлчилгээнүүдийг үзүүлж эхэлсэн ба энэ нь интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд ялгаатай хандах нөхцөлийг бий болгох бөгөөд үүнд хяналт тавих, шударга өрсөлдөх нөхцөл бүрдэж, хангагдаж байгааг тогтооход баримт бичгийн хүрээнд хязгаарлагдмал гэж үзсэн. Интернэтийн нөхцөл шаардлагад холболт болон харилцан холболтын зохицуулалтыг нарийвчлах нь тухайн зөвшөөрлийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийг ялгаатай нөхцөл бүхий зөвшөөрлүүд эзэмшиж буйг илрүүлэх, зохицуулалтыг чиглүүлэх боломжийг олгоно.

Дотоод интернэтэд тэгш холбогдох, дотоод урсгалыг нэмэгдүүлэх:	Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:	Судалгааны хүрээнд гарсан санал:
<p>2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний чанарыг сайжруулах, сүлжээ болон үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор интернэтийн дундын холболтын төвтэй 2-р түвшинд холболт үүсгэнэ.</p>	<p>Интернэтийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүгд бөөний үйлчилгээ эрхлэгчтэй үндсэн холболт үүсгэж байгаа хэдий ч тухайн холболтын хувьд техник холболтыг зөвхөн өөрийн сүлжээнээс шууд холбогдох эсэх нь тодорхойгүй байна.</p>	<p>Судалгаанд оролцогчдын 40 хувь нь бөөний үйлчилгээ эрхлэгчээр дамжин тус холболтыг үүсгэдэг мэдээлэл өгсөн.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Үйлчилгээ эрхлэгч үйлчилгээгээ үзүүлэхийн тулд ижил тэгш нөхцөл шаардлагыг биелүүлэх үүрэгтэй боловч зах зээлийн нөхцөл байдал болон үйлчилгээний хүртээмжээс хамаарч энэ зохицуулалтыг уян хатан болгох, үр ашигтай нь уялдуулан зохицуулах боломжтой байна.</p> <p><b>Одоогийн зохицуулалт:</b> Дундын холболтыг нэгдсэн байдлаар дэмжих зохицуулалт чухал уу эсхүл хэрэглэгчийн түвшинд үйлчилгээний чанарын түвшин чухал уу гэдэг асуудал гарч ирэх бөгөөд одоогийн нөхцөл энэ 2 ижил түвшинд байгаа тохиолдолд зарим үйлчилгээ эрхлэгчийн хувьд үр ашиггүй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.</p>		



<b>Үйлчилгээний хүртээмж, зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл:</b>	<b>Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:</b>	<b>Судалгааны хүрээнд гарсан санал:</b>
<p>2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлагын 4.1 дэхь заалтын дагуу сүлжээний үйлчилгээ эрхлэх зорилгоор харилцаа холбооны сүлжээ байгуулахгүй, харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс түрээсэлнэ. Сүлжээ байгуулах тохиолдолд зөвхөн өөрийн үйлчилгээгээ хүргэх зорилгоор хот суурин газрын сүлжээ байгуулж болно.</p>	<p>Хот суурин газрын сүлжээ байгуулах эрхтэй байна. Түүнийг түрээслэх эрхгүй байна.</p>	<p>Байгууллагын хэрэглэгч нь өөрийн байр талбайд үйлчилгээ авах тохиолдолд хамгийн том асуудал нь дэд бүтэц байдаг бөгөөд ихэнх тохиолдолд үйлчилгээ эрхлэгч нь дэд бүтцийг шийдвэрлэж холболт үүсгэдэг байна. Энэ нь интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь дэд бүтцээс хэт хамааралтай байгааг илэрхийлж байгаа бөгөөд өөрийн дэд бүтцийг байгуулах эсхүл үйлчилгээ хүргэхгүй байх сонголттой тулгардаг.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Байгууллагын хэрэглэгчийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж нь дэд бүтэцтэй шууд хамааралтай. Ингэж дүгнэх үндэслэл нь байгууллагын авч буй урсгалын дундаж хэмжээ нь 30mbps гэрээний үндсэн нөхцөл нь шууд холболт үүсгэх бөгөөд хэрэглэгчийн хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зах зээлд өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэх, шинэ хэрэглэгчийг бий болгоход дэд бүтцийг чөлөөтэй байлгах зохицуулалт чухал байна.</p>		

<b>Хэрэглэгчийн сонголтыг чөлөөтэй байлгах:</b>	<b>Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:</b>	<b>Судалгааны хүрээнд гарсан санал:</b>
<p>2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн үйлчилгээний үнэ тарифаа Зохицуулах хорооноос баталсан аргачлалын дагуу тогтоож, олон нийтэд ил тод мэдээлнэ.</p>	<p>Судалгааны хүрээнд байгууллагын үнэ тарифийн судалгааг баримт бичгийн хүрээнд хийхэд ил тод байхгүй байна.</p>	<p>Санал болгож буй үйлчилгээ, байршил болон технологийн боломж нь тодорхойгүй байгаагаас шалтгаалан үнэ тарифаа ил зарлах боломжгүй байдаг байна.</p>
<p><b>Дүгнэлт:</b> FTTH, FTTB дэд бүтэц бүрэн нэвтэрсэн, эцсийн хэрэглэгчийн цэг дээр үйлчилгээг солих боломжтой орнуудад үнэ тариф нь нээлттэй байдаг байна.</p>		



Байгууллагын хэрэглэгчийн түвшин үйлчилгээний зааг ялгааг тодорхойлох:	Нөхцөл шаардлагад хийсэн шинжилгээ:	Судалгааны хүрээнд гарсан санал:
<p>4.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчээс интернэтийн үйлчилгээтэй холбоотой гомдол, санал хүлээж авах, шийдвэрлэх журамтай байх ба гомдол маргааныг үл ялгаварлах, шуурхай байдлаар шийдвэрлэнэ.</p>	<p>Хэрэглэгч үл хамаарсан ерөнхий нөхцөл, шаардлага</p>	<p>Асуулгын явцад байгууллагын хэрэглэгч нь үйлчилгээ эрхлэгчтэй байнгын техник туслалцааны гэрээ байгуулаагүй тохиолдолд хүндрэл их гардаг гэсэн байна.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хэрэглэгчийн түвшинд үйлчилгээг тодорхойлоогүй тохиолдолд зохицуулагч гомдол маргаанд оролцох боломжгүй байна. Учир нь хэрэглэгчийн зохицуулалт агуулга нь хэт ерөнхий байгаа хэдий ч зах зээл дээр хэрэглэгчийн авч буй үйлчилгээ технологи хамрах хүрээнээс хамаарч олон түвшинтэй болсон байна.</p>		

## Долоо. ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА:

Байгууллагын интернэт (CORPORATE) хэрэглэгчийн онцлог, хэрэгцээ шаардлагын талаарх судалгааны хүрээнд интернэт, интернэтийн дэд бүтэц болон үйлчилгээний агуулгаар зохицуулалтын судалгааг хийсэн ба судалгааны хүрээнд тухайн үйлчилгээний зохицуулалтын гол чиглэл нь үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, дэд бүтцийг үр дүнтэй хамтран ашиглах, үр ашигтай (WinWin) байх асуудал чухал байр суурьтай байсан бөгөөд үүнийг зохицуулахдаа тусгай зөвшөөрлийн агуулга, хамрах хүрээгээр хэрэгжүүлэхийг олон улсад зөвлөмжилж байна.


Интернэтийн зохицуулалттай холбоотойгоор нийтлэг хандлага бол интернэтийг олон улсыг хамарсан уян хатан дэд бүтэц бөгөөд үүнийг үр дүнтэй ашиглах, үр шимийг нь хүртэх нь тухайн оролцогч бүрийн хүчин чармайлттай шууд хамааралтай асуудал бөгөөд нэгдсэн систем бодлого, технологи чухал гэж үзсэн. Тиймээс ч дэлхий нийтээр нэгдсэн уриалгуудыг гарган нэгдсэн стандарт шаардлагуудыг бий болгох хүчин чармайлтыг хэрэгжүүлж байна.

(ITU, WTIS, Internet Policy and Governance)

<https://www.itu.int/en/action/internet/Pages/default.aspx>

### Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас интернэтийн зохицуулалттай холбоотой хэсгийг товч дурдав.

Өнөөгийн дижитал технологиуд нь шинэ бизнесийн загваруудыг танилцуулж, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, эцсийн дүндээ дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд авчрах үр өгөөжийг өөрчилснөөр эдийн засгийн бараг бүх салбарыг өөрчилж байна. Энэ нь иргэдэд болон бизнесийн бүхий л орчинд илүү сайн ирээдүйг бий болгоход чиглэгдэж байгаа боловч зах зээлийг үр



дүнтэй ажиллуулахын тулд тэдгээрийг дэмжих бодлого, зохицуулалтын орчин дагалдан сайжирч байх ёстой гэж дүгнэсэн.

Дэлхий даяар өргөн зурвасын сүлжээнүүд болон тэдгээрт нэвтрэх үйлчилгээ нь бидний өдөр тутмын амьдралын чухал хэсэг болж байна. Технологи, хэрэглээний хэв маяг хурдацтай өөрчлөгдөж, нэгдэж буй МХХТ-ийн салбар нь 20 жилийн өмнөх уламжлалт харилцаа холбооны орчноос тэс өөр байгаа бөгөөд өнөөдрийн бидний гаргасан бодлого зохицуулалтын орчныг төөсөөлж байснаас эрс өөрчлөгдсөн байна. *(ITU, GSR-21 symposium)*

Эдгээр өөрчлөлтүүд нь зохицуулалтын бодлогод хүндрэл учруулж байна.

- Үндсэн технологи хурдацтай хөгжиж, өргөн хүрээний, байнга өөрчлөгддөг үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгож буй өргөн зурвасын сүлжээнд зохицуулалтыг хэрхэн тодорхойлох ёстой вэ?

- Зах зээлд аль үйлчилгээ, үйлчилгээ эрхлэгч илүү эрх мэдлийг эдэлж байгааг тодорхойлох ?


- Бодлого боловсруулагчид ямар чиглэлд анхаарах ёстой вэ, зохицуулагчид хэрэглэгчдэд үр ашигтай боловч өрсөлдөөнд сөрөг нөлөөтэй, үр дагавартай арилжааны стратегитай хэрхэн харьцах ёстой вэ?

Сүүлийн жилүүдэд гарсан технологийн үндсэн өөрчлөлтүүд нь үйлчилгээ болон технологийн хоорондын нягт уялдаа холбоог сулруулж, харилцаа холбооны эрх зүйн зохицуулалтын либералчлах үйл явцыг хурдасгаж өгсөн. Энэ нь Европын комиссын шийдвэр ("Open Network Provision" (ONP) гэж нэрлэгддэг. 1998) бөгөөд 2003 онд бүх цахим харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг хамарсан нь зохицуулалтын байгууллагууд конвергенцэд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгаагийн жишээ болсон бөгөөд өөр өөр сүлжээгээр нэг ижил үйлчилгээг үзүүлэх боломжтой үр дүнтэй сүлжээнүүд бий болж, сүлжээ нь өмнөхөөсөө илүү өргөн хүрээний үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгож, өмнөхөөсөө илүү хүчирхэг цар хүрээ, хэмнэлтийг бий болгосон үр дүн юм.

Энэ хүрээнд зохицуулалтад тавигдсан гол асуудлуудын нэг нь нэгдсэн тусгай зөвшөөрлийн асуудал бөгөөд дараах үндсэн агуулгыг агуулсан байх ёстой гэсэн чиглэлтэй байна. Үүнд:

- ◆ Тусгай зөвшөөрлийн зорилго нь МХХТ-ийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх явдал юм.
- ◆ Зөвшөөрлийн оновчтой бүтэц, лицензийн нөхцөл нь улс орон бүрт өөр өөр байх боловч зорилго нь орлогыг нэмэгдүүлэх ёсгүй;
- ◆ Хөрөнгө оруулалт, инновацыг дэмжих, хэрэглэгчийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд ерөнхий зөвшөөрлийг илүүд үзэж, зөвхөн захиргааны зардлыг нөхөхийн тулд хураамжийг өчүүхэн бага байлгахад чиглэх.





- ◆ Барилга байгууламжид суурилсан тусгай зөвшөөрөл олгосон тохиолдолд хөрөнгө оруулалтыг шаардлагагүй давхардлаас зайлсхийхийн тулд тусгай зөвшөөрлийн тоог хязгаарлах ёстой, гэхдээ тэдгээр нь үндсэн дэд бүтцэд шударга, боломжийн нөхцөлөөр нээлттэй нэвтрэх нөхцөлийг хангасан байх ёстой<sup>1</sup>, өрсөлдөөнт үйлчилгээний зах зээл.
- ◆ Тусгай зөвшөөрөл эзэмшигчид зөвхөн өрсөлдөөний бодлогыг харгалзан дэд бүтцээ хуваалцаж, нэгдэхийг зөвшөөрөх ёстой.

Дээрх нөхцөл байдлаас гадна тухайн улсын сонгосон лицензийн хүрээ нь тухайн салбарын өсөлтөд шууд нөлөөлж болох бөгөөд энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийг зах зээлд үйлчилгээ нэмэхийг хүсэх бүртээ шинэ лиценз авахыг шаардах замаар зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарлах системээс гадна үйлчилгээг нээлттэй илүү өргөн хүрээнд хүргэх боломжийг ч бүрдүүлж болох юм.

Дэлхий дахинд тусгай зөвшөөрөл олгогдсон хэвээр байгаа бөгөөд олон үйлчилгээ (Multiservice) болон нэгдсэн лиценз (Unified)-ийн тогтолцоо нь лицензийг илүү оновчтой болгох, технологийн нэгдмэл байдлыг дэмжих, өрсөлдөөнийг дэмжих боломжтой учраас олон улсын шилдэг туршлага болон гарч ирсээр байна.

Шинэ технологи, үйлчилгээнд одоо байгаа болон хоцрогдсон зохицуулалтыг ашиглах нь инновацыг боомилох эрсдэлтэй. Технологийн хөгжилд илүү сайн хөл нийлүүлэхийн тулд бодлого боловсруулагчид болон зохицуулагчид тодорхой, уян хатан, бодитойгоор хэрэгжүүлэх янз бүрийн арга хэмжээг судалж нэвтрүүлэх шаардлагатай байна.

Аливаа ахиц дэвшилд саад учруулахаас зайлсхийх эдгээр зохицуулалтын арга замуудад спектрийг ашиглах, шинэ технологийн зөвшөөрлийг бий болгох, бүх нийтийн хүртээмжийг хөнгөвчлөх шинэлэг аргууд багтдаг.

Зохицуулалтын туршилт хийх (sandbox) аюулгүй орон зайг бий болгох шилдэг туршлага нь шинийг санаачлагч буюу бизнесийн шинэ загваруудыг тохируулах, тодорхойлох, шинэ дижитал үйлчилгээний уян хатан байдлыг бий болгох боломжийг олгодог бөгөөд ингэснээр хүмүүс болон бизнесүүдэд эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааны шинэ боломжийг нэмэгдүүлдэг гэж үзсэн байна.


[https://www.itu.int/dms\\_pub/itu-d/opb/pref/D-PREF-TRH.1-2020-PDF-E.pdf](https://www.itu.int/dms_pub/itu-d/opb/pref/D-PREF-TRH.1-2020-PDF-E.pdf)

### **Сингапурын интернэт үйлчилгээний тусгай зөвшөөрөл**

Сингапурт интернэтийн үйлчилгээ (Internet access service) үзүүлэхэд Facility based operation эсвэл Service based operation тусгай зөвшөөрөлтэй байхаас гадна Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу Internet access service provider-ын класс тусгай зөвшөөрөл авдаг. Мөн нийтийн үйлчилгээний газарт буюу интернэт кафе,

---

<sup>1</sup> See, for example, Digital Regulation Platform thematic sections on “Red Compartida, Mexico” and “A single integrated wholesale broadband network in Brunei”.



нийтийн номын сан, боловсролын байгууллагад интернэт үйлчилгээ үзүүлэхэд “Internet service reseller” гэсэн класс лиценз авах шаардлагатай байдаг.

Facility based operation (FBO) тусгай зөвшөөрлийн хүрээнд цахилгаан холбооны сүлжээ, систем, төхөөрөмж байгуулж цахилгаан холбооны (switching and/or telecom services) үйлчилгээг бусад тусгай зөвшөөрөлтэй телеком операторууд, бизнесүүдэд эсвэл эцсийн хэрэглэгчид үзүүлэх боломжтой.

Service based operation (SBO) тусгай зөвшөөрлийн хүрээнд FBO оператороос цахилгаан холбооны сүлжээний элементүүд (сүлжээний урсгал, холболт/switching service) түрээслэн өөрийн телеком үйлчилгээг үзүүлэх, гуравдагч этгээдэд дамжуулан түрээслэх, эсвэл өөрийн өмчлөлийн байгууламжид телеком сүлжээ, систем, төхөөрөмж байгуулж гуравдагч этгээдэд телеком үйлчилгээ үзүүлэх боломжтой байна.

SBO-ийн үйл ажиллагааны чиглэлээс хамааруулж дотор нь дараах 2 төрөлд хуваадаг. Үүнд:

1. SBO (Individual) Licence – Улс хоорондын урсгал түрээсэлж үйлчилгээ үзүүлэх тохиолдолд Individual тусгай зөвшөөрөл олгох ба жилийн орлогоос хамааруулж эхний 50 саяын орлогод жилд 4000 сингапур доллар, дараагийн 50-100 саяд 0.5%, 100 саяас дээш орлогото бол орлогын 0.8% зохицуулалтын төлбөр төлдөг.
2. SBO (Class) Licence – бусад буюу аудио текст, яриа, VoIP, Улс хоорондын яриа, store-and-retrieve VAS, resale PSTN, Payphone зэрэг үйлчилгээ үзүүлэхэд олгодог ба нэг удаагийн 200 сингапур долларын бүртгэлийн хураамж төлдөг.


Internet access service provider класс тусгай зөвшөөрөл нь интернэт үйлчилгээ үзүүлэгчдэд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу автоматаар дагаж олгогддог тусгай зөвшөөрөл ба контенттой холбоотой шаардлагуудыг тавьдаг. Хуулийн дагуу интернэтийн үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш 14 хоногт бүртгүүлэх үүрэгтэй ба жилд 1000 Синга долларын хураамж төлдөг байна.

## **Малайзын интернэт үйлчилгээний тусгай зөвшөөрөл**

Малайз улс харилцаа холбооны салбарын нэгдэн нийлж буй (convergence) хөгжилд нийцүүлэн харилцаа холбоо, мультимедиа салбар дахь тусгай зөвшөөрийг технологи болон үйлчилгээний төрлөөс үл хамаарааруулж (both technology and service neutral) олгох зохицуулалттай байна. Иймд интернэтийн үйлчилгээ үзүүлэхэд зориулсан тухайлсан тусгай зөвшөөрөл гэж байхгүй.

Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь 1998 оны Харилцаа холбоо, мультимедиа хуульд заасны дагуу зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарсан дараах 4 төрөлтэй. Ингэснээр үйлчилгээ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа тэлэх, сүлжээ дэд бүтцийг илүү үр ашигтай ашиглах боломжийг олгоно гэж үздэг байна.

Харилцаа холбоо, мультимедиа хуульд заасан тусгай зөвшөөрлийн төрлүүд:



1. Network Facilities Provider буюу Сүлжээний төхөөрөмж эзэмшигч – Сансрын хиймэл дагуулын газрын станц, өргөн зурвасын шилэн кабель, цахилгаан холбооны шугам, холболтын станц, радио холбооны дамжуулах төхөрөөмж, хөдөлгөөнт үүрэн холбооны бааз станцууд, өргөн нэвтрүүлгийн дамжуулах цамхаг ба төхөөрөмжийг эзэмшигч этгээд энэ зөвшөөрлийг авна. Эдгээр нь сүлжээ, аппликэйшн, контентийн үйлчилгээг үзүүлэх нэгдэн нийлэлтийн суурь бүтэц (convergence model) юм.
2. Network Services Provider буюу Сүлжээний үйлчилгээ үзүүлэгч – Төрөл бүрийн аппликэйшнийг дамжуулах суурь холболт, зурвасын өргөнөөр хангана. Сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид нь ялгатай сүлжээ хооронд холболт, дамжууллын боломжийг бүрдүүлдэг. Сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид нь ерөнхийдөө сүлжээний төхөөрөмжийг эзэмшигчид байдаг. Гэхдээ бусдаас түрээслэн үйлчилгээ үзүүлэх ч боломжтой.
3. Applications Service Provider буюу Аппликэйшн үйлчилгээ үзүүлэгч – Тодорхой төрлийн үйлчилгээг тухайлбал яриа, дата үйлчилгээ, контент суурьтай үйлчилгээ, цахим худалдаа болон дамжууллын үйлчилгээг эцсийн хэрэглэгчид үзүүлдэг.
4. Content Applications service providers буюу буюу Контент аппликэйшн үйлчилгээ үзүүлэгч - Уламжлалт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ болон онлайн мэдээллийн үйлчилгээнүүд хамаарна.


Тусгай зөвшөөрлийг дээр дурдсан 4 төрлөөс гадна зохицуулалтын агуулгаар нь 2 хуваадаг. Үүнд:

- a) **Individual licence** буюу “тусгай” зөвшөөрөл нь зохицуулалтын өндөр хяналтыг шаардах ба тусгай эсхүл нэмэлт нөхцлүүд тавина. Индивидуал лицензийг Яамнаас олгох ба тусгай ба нэмэлт нөхцлүүдийг Яамнаас баталж, өөрчлөх эрхтэй байдаг.
- b) **Class licence** нь “light handed” буюу хөнгөн зохицуулалттай байх ба зах зээлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн, зах зээлд хялбар нэвтрэх боломжийг олгодог байна. Класс лиценз нь ерөнхийдөө бүртгэлийн шинж чанартай.

Дараах хүснэгтээр тусгай зөвшөөрлийн төрөл ба зохицуулалтын агуулгын уялдаа холбоог харуулахаас гадна харилцаа холбооны үйлчилгээнүүд аль зөвшөөрөлд хамаарч буйг харуулсан.

	Individual licence	Class licence	Зөвшөөрөл авахгүй үйлчилгээ
Network Facilities Provider	Газрын станц Суурин кабель, линкүүд Радио холбооны дамжуулагч Хиймэл дагуулын HUB Хиймэл дагуулын хяналтын станц	Хязгаарлагдмал хүрэн дэх сүлжээний төхөөрөмжүүд	Өргөн нэвтрүүлгийн студи Сүлжээний дагалдах төхөөрөмжүүд Хувийн сүлжээний төхөөрөмжүүд






	Сансрын станц Цамхаг, шон, худаг сувагчлал Бусад		
Network Services Provider	<b>Өргөн зурвасын үйлчилгээ (Bandwidth services)</b> Өргөн нэвтрүүлгийн түгээх үйлчилгээ <b>Хөдөлгөөнт үүрэн үйлчилгээ</b> <b>Аксесс аппликэйшн үйлчилгээ</b> Сансрын үйлчилгээ Холболтын үйлчилгээ Гэйтвэй үйлчилгээ Бусад	Хязгаарлагдмал хүрэн дэх хэрэглэгчийн холболт эсхүл холболтын үйлчилгээ	Incidental network үйлчилгээ LAN үйлчилгээ Хувийн сүлжээний үйлчилгээ
Applications Service Provider		PSTN үйлчилгээ <b>Нийтийн үүрэн холбооны үйлчилгээ</b> IP телефон Нийтийн таксфон Дата үйлчилгээ Аудио текст хостинг Лавлах үйлчилгээ <b>Интернэт аксесс үйлчилгээ</b> Мессежийн үйлчилгээ Клауд үйлчилгээ	Электрон шилжүүлгийн үйлчилгээ Интерактив шилжүүлгийн үйлчилгээ Зар сурталчилгааны самбар Вэб хостинг
Content Applications service providers	Хиймэл дагуулын өргөн нэвтрүүлэг Subscription broadcasting Terrestrial free to air TV Terrestrial radio broadcasting бусад	Дараах хязгаарлагдмал хүрэн дэх контент үйлчилгээ • Тээврийн хэрэгсэл, галт тэрэг, онгоцонд • Нэг орон сууцны эсхүл үйлчилгээний байшинд • Хязгаарлагдмал газар зүйн бүсэд Тусгай төхөөрөмжөөр хүлээн авагч ашигладаг тодорхой хэсэг сонирхлын бүлэгт Газар зүйн хувьд өөр газар үүсгэсэн контентийг сүлжээгээр дамжуулан дэлгэц дээр үзүүлэх үйлчилгээ Зайн сургалтын контент үйлчилгээ Спорт, урлагын нэг удаагийн арга хэмжээтэй үйлчилгээ	Интернэт контент аппликэйшн үйлчилгээ

Эдгээрээс дүгнэхэд өргөн зурвасын интернэтийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор шилэн кабель татаж сүлжээ байгуулах бол “Network Facilities Provider”, интернэт урсгал түрээслүүлэх бол “Network services provider” Individual “тусгай” зөвшөөрлүүдийг авах ба эцсийн хэрэглэгчид интернэт үйлчилгээ үзүүлэх бол “Applications service provider” класс зөвшөөрлийг авч байна.

Мөн хязгаарлагдмал хүрээнд хэрэглэгчийг холбох сүлжээ байгуулахад класс тусгай зөвшөөрөл авна. 2002 оны Яамны зөвлөмжид дурдсанаар класс тусгай зөвшөөрөлд хамаатуулах хязгаарлагдмал хүрээг тодорхойлохдоо сүлжээний төхөөрөмж нь хязгаарлагдмал зориулалттай, олон нийтийн зөвхөн тодорхой хэсгийг л хамардаг байна гэсэн. Олон нийтэд үйлчлэх сүлжээний хувьд сүлжээний багтаамж, орлуулах боломжийг авч үздэг бол хязгаарлагдмал хүрээний үйлчилгээний хувьд зөвхөн тодорхой зориулалтыг авч үздэг байна. Мөн бусад үйлчилгээ эрхлэгчээс хамаарал, тухайлбал урсгал хязгаарлагдах уу, төхөөрөмж боттлнэк болох уу зэрэг шалгуур бага байна.



Хязгаарлагдмал хүрээний “Network Facilities Services” үйлчилгээний жишээнүүд:

1. Нийтийн мобайл радио сүлжээний радио холбооны дамжуулагч  
*Radiocommunications transmitters for Public mobile radio network services*
2. Нийтийн радио пэйжийн сүлжээний радио холбооны дамжуулагч  
*Radiocommunications transmitters for Public radio paging network services*
3. Өргөн зурвасын цэгээс цэгт эсвэл цэгээс олон цэгт утасгүй интернэт сүлжээний радио холбооны дамжуулагч  
*Radiocommunications transmitters and links for broadband point to point and point to multipoint wireless internet network services*
4. Нийтийн утасгүй видео холбооны радио холбооны дамжуулагч  
*Radiocommunications transmitters and links for public wireless video communications*
5. Нийтийн утасгүй дата сүлжээний радио холбооны дамжуулагч  
*Radiocommunications transmitters and links for public wireless data network services*
6. Нэг барилга, нэг барилгын комплекст өргөн зурвасын сүлжээний свич, мультиплексүүд, суурин линкийн үйлчилгээ  
*Network of broadband access switches or multiplexers and fixed links and the cables offered for the sole purpose of end users in a building or a single clustered building complex*

[https://www.mcmc.gov.my/skmmgovmy/media/General/pdf2/Suruhanjaya-Komunikasi-dan-Multimedia-Malaysia\\_Licensing-Guidelines.pdf](https://www.mcmc.gov.my/skmmgovmy/media/General/pdf2/Suruhanjaya-Komunikasi-dan-Multimedia-Malaysia_Licensing-Guidelines.pdf)

## ДҮГНЭЛТ

Байгууллагын интернэт (CORPORATE) хэрэглэгчийн онцлог, хэрэгцээ шаардлагын талаарх судалгааг интернэтийн тусгай зөвшөөрөл бүхий нийт үйлчилгээ эрхлэгчээс асуулга, тоон судалгааг хослуулан авч ярилцлагын аргаар үр дүнг гаргасан. Энэ хүрээнд тодруулсан асуулгаар нийт 30 үйлчилгээ эрхлэгчээс асуулга, ярилцлагын аргаар нэмэлт тодруулга, мэдээлэл цуглуулан энэхүү судалгаа хийж гүйцэтгэлээ.


Зохицуулалтын санал боловсруулах хүрээнд энэхүү судалгаа болон зах зээлийн нөхцөл байдал, тулгамдаад байгаа асуудлуудтай уялдуулан дараах голлох дүгнэлтийг энд тусгаж байна.

### Байгууллагын интернэт үйлчилгээний нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл:

- ❖ Судалгаанд хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн байгууллагын хэрэглэгчийн зах зээл хэт төвлөрөлтэй буюу зах зээлийн 51 хувь нь нэг хэрэглэгчид бүртгэлтэй байна.
- ❖ Үлдсэн 46 хувь нь 4 үйлчлэгч, 3 хувь нь 20 үйлчилгээ эрхлэгчид бүртгэлтэй байна.
- ❖ Зөвхөн групп компанид үйлчилгээ үзүүлдэг 3 үйлчилгээ эрхлэгч байна (ХХЗХ-н хяналтын тайлан CRC.ISP.inspectionreport2023)



- ❖ Салбарын хувьд интернэтийн үйлчилгээнээс олсон орлогын хувь хэмжээгээр өрхийн орлого 54 хувьтай байгаа бол байгууллагын үйлчилгээнээс олсон орлого 44 хувьтай байна.
- ❖ Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын дүнгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 56 мянган аж ахуйн нэгж байгаагаас 25.8 мянган аж ахуйн нэгж интернэт ашигалж байна. Үүний 17.4 мянга (67.2%) нь харилцагч/хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх, 14.5 мянга (56.3%) нь имэйл авах/илгээхэд, 13.7 мянга (53.2%) нь интернэт банкны үйлчилгээнд хамрагдах, 12.6 мянга (48.8%) нь санхүүгийн бусад үйлчилгээнд хамрагдах, 10.9 мянга (42.4%) нь бараа бүтээгдэхүүний мэдээ, мэдээлэл авах, илгээх, 9.5 мянга (37.0%) нь төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах зорилгоор байна. Энэ тоо нь ХХЗХ-ны тоон мэдээлэлтэй үндсэндээ тохирч байна.
- ❖ Сүүлийн 8 жилийн хугацаанд байгууллагын интернэт хэрэглэгчийн тооны өсөлтийн хувь өндөр байгаа хэдий ч тогтмол бус 2023 онд 10% өсөлттэй байна.
- ❖ Нийт хэрэглэгчийн 67 хувь нь Улаанбаатар хотын, 23 хувь нь орон нутгийн хэрэглэгч гэж бүртгэгдсэн байх бөгөөд тэдэнд гэрээлсэн нийт урсгалын хэмжээ нь 431,676 Mbps бол үүний Улаанбаатар хотын хувь хэмжээ нь 79 хувь, орон нутгийн хувь хэмжээ нь 21 хувь байна.
- ❖ Нийт хэрэглэгчийн 82 хувь нь бизнесийн, 15 хувь нь төрийн, 2 хувь нь Төрийн бус, үлдсэн 1 хувь нь бусад гэсэн ангиллаар хэрэглэгч болсон байна.
- ❖ Зах зээлд хамгийн түгээмэл буюу олон хэрэглэгч бүхий бүлэг нь 30Mbps гэсэн тоон үзүүлэлт байгаа бөгөөд нийт хэрэглэгчийн 40 хувь нь тус бүлэгт хамаардаг байна.
- ❖ Нийт байгууллагын 80 орчим хувь нь өөрийн сүлжээнд физик байдлаар нөөц (cache) сервэрийг зохион байгуулсан ба Facebook, Google, Akamai, Microsoft зэрэг сервэрүүд байна. Ачааллын хувьд Facebook, Google-ийн ачаалал харьцангуй өндөр (өрхийн хэрэглэгчийн масстай шууд хамааралтай ба байгууллагын хэрэглэгчтэй шууд хамааралгүй байдаг нь ярилцлагын үед тогтоогдсон.)
- ❖ Нийт үйлчилгээ эрхлэгчдийн 80 хувь нь хэрэглэгчиддээ Зохицуулалттай интернэт (managed internet), Дотоод сүлжээ (Wi-Fi зохион байгуулах гм), Дата төвд сервер байршуулах, сервер түрээслэх, хостинг зэрэг үйлчилгээг хүргэдэг байна.
- ❖ Байгууллага дээрх интернэтийн гол хэрэглээ 100% оффис хэрэглээгээ бүрдүүлэхээс гадна хэрэглэгчийн үйлчилгээ, камер хяналт, дотоод дэд бүтцэд хавсран хэрэглэдэг хэрэглээ дийлэнх хувийг бүрдүүлж байна.
- ❖ Байгууллагуудын хувьд интернэтийн үйлчилгээ эрхлэгчийг сонгох шалтгаан, хүчин зүйлсэд интернэтийн хурд, үнэ тариф нөлөөлдөг бол нөгөө талаас анх сонгож үйлчлүүлсэн байгууллагаа солиогүй, урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд үйлчилгээ авч буй юм.
- ❖ Санал асуулгад оролцсон 8 байгууллагаас нийт 6-д нь тухайн интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас сүлжээний дэд бүтэц холбосон гэсэн



мэдээлэлтэй, 1 байгууллага өөрсдөө сувагчлал татсан бол 3 байгууллага нь тухайн байршилд сувагчлал дэд бүтцийн талаар мэдээлэл байхгүй байна.

### **Хэрэглэгчийн сэтгэл ханамж:**


- ❖ Байгууллагуудын хувьд интернэтийн үйлчилгээ эрхлэгчийг сонгох шалтгаан, хүчин зүйлсэд интернэтийн хурд, үнэ тариф нөлөөлдөг гэж илэрхийлсэн.
- ❖ Санал асуулгад оролцсон байгууллагаас 80 орчим хувь нь тухайн интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас сүлжээний дэд бүтэцэд холбосон, дотоод холболт, сувагчлалыг шийдэж өгсөн гэж хариулсан.
- ❖ 50 болон түүнээс дээш ажилтантай байгууллагуудын хувьд IT хариуцсан мэргэжилтэн болон нэгжтэй байна.
- ❖ Байгууллагын хэрэглэгчид нэмэлт хэрэглээ болон үнийн хөнгөлөлт нь сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.
- ❖ Интернэтийн үйлчилгээндээ сэтгэл ханамж хэр байгааг 1-10 оноогоор дүгнүүлэхэд 7-9 оноо өгсөн хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамжийн түвшин өндөр, үйлчилгээ эрхлэгчээ солих бодолгүй байна гэж 80 орчим хувь нь илэрхийлсэн.
- ❖ Интернэтийн хурд болон үйлчилгээ үзүүлэх, гэмтэл саатал шийдвэрлэх хугацаа зэргээс шалтгаалан үйлчилгээгээ солих сонирхол нэмэгддэг байна.

### **Зохицуулалтын нөхцөл, шаардлага**

Нөхцөл шаардлагад судалгааны хүрээнд гарсан үр дүн болон зах зээлийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинжилгээг хийсэн.


- ❖ Нөхцөл шаардлагын хувьд судалгаанд оролцогчид тус баримт бичгийг мөрдөж ажиллахад хүндрэлтэй биш үйл ажиллагаанд тохиромжтой байгаа гэж хариулсан хэдий ч 23 хувь нь тус баримт бичгийг сайжруулах шаардлагатай гэж үзсэн.
- ❖ Зах зээлд үүссэн нөхцөл байдал болон үйлчилгээ эрхлэгчдийн дэд бүтэц, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, чиглэлд уялдсан зохицуулалтын агуулгыг тусгах, тодорхойлох шаардлагатай байна.
- ❖ Одоо мөрдөгдөж буй зохицуулалтын агуулга нь газар зүйн хувьд хамрах хүрээг тодорхойлж байгаа боловч түүнд уялдсан зохицуулалтын уялдаа баримт бичигт тусгагдаагүй байна.
- ❖ Үүссэн нөхцөл байдал болон зохицуулалтын баримт бичигт тусгагдсан агуулга тус бүрээр дор дүгнэлт гаргав.
  - Зохицуулалтын хувьд үйлчилгээ хүргэх технологийн сонголт, боломж нь нээлттэй мэт боловч технологи хооронд шилжих үйлчилгээг саадгүй хүргэх үед үйлчилгээ эрхлэгчийг зөвшөөрлийн хамрах хүрээ хязгаарлаж байна.





- Бөөний үйлчилгээ эрхлэгч нь гадаад урсгалаас гадна нэмэлт үйлчилгээнүүдийг үзүүлж эхэлсэн ба энэ нь интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд ялгаатай хандах нөхцөлийг бий болгох бөгөөд үүнд хяналт тавих, шударга өрсөлдөх нөхцөл бүрдэж, хангагдаж байгааг тогтооход баримт бичгийн хүрээнд хязгаарлагдмал гэж үзсэн.
- Байгууллагын хэрэглэгчийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж нь дэд бүтэцтэй шууд хамааралтай. Ингэж дүгнэх үндэслэл нь байгууллагын авч буй урсгалын дундаж хэмжээ нь 30mbps гэрээний үндсэн нөхцөл нь шууд холболт үүсгэх бөгөөд хэрэглэгчийн хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зах зээлд өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэх, шинэ хэрэглэгчийг бий болгоход дэд бүтэцийг чөлөөтэй байлгах зохицуулалт чухал байна.
- Эцсийн хэрэглэгчид хүрч буй үйлчилгээний үнэ тариф, өртөг нь зөвхөн интернэтээс гадна олон хүчин зүйлээс хамааралтай түүнийг шийдвэрлэх нь үнэ тарифийг хэлцлийн хэмжээнд хүргэдэг бөгөөд энэ нь үйлчилгээ эрхлэгч болгон харилцан адилгүй байгаа буюу байгууллагын хэрэглэгчийн хувьд дэд бүтэц, авч буй үйлчилгээний агуулга чухал гэх баталгаа нь үнэ тариф тогтсон тогтмол бус, илт тод байхгүй байгаагаар дүгнэж болно.





**“БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТ (CORPORATE) ХЭРЭГЛЭГЧИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА”-ны асуулга:**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2025 он хүртэлх дунд хугацааны стратеги зорилгуудыг “Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах тэгш, хүртээмжтэй харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ”, “Харилцаа холбооны салбарт өрсөлдөөн, инновацийг дэмжин, хөгжлийг эрчимжүүлж, цахим үйлчилгээ хөгжих орчин болон харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.” гэж тодорхойлсон. Энэхүү зорилтын хүрээнд цахим үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, дижитал шилжилт, дижитал эдийн засгийг дэмжихэд төрийн болон бизнесийн бүх төрлийн байгууллагуудын интернэт холболт, хэрэглээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний боломж нөхцөл уян хатан байхад зохицуулалтыг чиглүүлэх зорилгоор дараах судалгааг авч байна.

Жич: Судалгааны мэдээллийг тайланд зөвхөн нэгтгэсэн мэдээлэл хэлбэрээр ашиглах ба тухайлсан компанийн нэрийг дурдахгүй болно.

**Судалгааны асуулгыг хавсралтаар хүргүүлсэн эксел файл дээр бөглөнө.**

**1. Үйлчилгээ эрхлэгчийн үндсэн мэдээлэл**

1.1. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

*Хариулт хэсэгт мэдээллийг бөглөж оруулна.*

№	Асуулт	Хариулт
1	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр:	
2	Тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ:	
3	Тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа:	

1.2. Интернэтийн бөөний урсгалын мэдээлэл

*Урсгал түрээслэн авч байгаа чиглэл тус бүрээр бөөний үйлчилгээ эрхлэгчийн нэр, урсгалын хэмжээ, тухайн этгээдээр дамжин интернэт холболтын төв (MIX)-д холбогддог эсэхийг бичнэ.*


№	Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгч	Авч буй нийт гадаад урсгалын хэмжээ (Mbps)	Тухайн үйлчилгээ эрхлэгчээр дамжиж MIX-д холбогддог эсэх (тийм/ үгүй)
	1	2	3
1			
2			
3			
4			
...	....		

1.3 Кэйш серверийн мэдээлэл

1.3.1 Өөрийн сүлжээнд кэйш сервертэй эсэх  Тийм  Үгүй

1.3.1.1 **Тийм бол** нэр кэйш сервер тус бүрээр нэр, зориулалт, төрөл, сарын ачаалалын мэдээллийг доорхи хүснэгтэд бөглөнө үү.

№	Кэйш серверийн нэр	Зориулалт	Төрөл	Сарын ачаалал, Mbps




1.3.2 Гадаадын серверт шууд холболт хийдэг эсэх  Тийм  Үгүй

1.3.2.1 **Тийм бол** гадаад серверийн нэр зориулалт, төрөл, сарын ачаалалын мэдээллийг доорхи хүснэгтэд бөглөнө үү.

№	Гадаад серверийн нэр	Зориулалт	Төрөл	Сарын ачаалал, Mbps

## 2. Үндсэн болон нэмэлт үйлчилгээний талаарх мэдээлэл

Хэрэглэгчийн тоог байршил (УБ болон орон нутаг), төрлөөр ангилж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж бичнэ. Тухайн төрлийн хэрэглэгчдийн гэрээт хурдны нийлбэрийг багана 3-д нөхнө. Төрийн байгууллага гэдэгт УТҮГ-аас бусад улсын төсвөөс санхүүждэг бүх төрлийн байгууллагыг (төрийн захиргааны болон эмнэлэг, сургууль, цэцэрлэг гм) оруулж тооцно.

2.1. Улаанбаатар хотын байгууллагын хэрэглэгчийн мэдээлэл:

№	УБ хотын хэрэглэгчийн төрөл	Тоо	Гэрээт хурдны хэмжээ нийт (Mbps)
0	1	2	3
1	Төрийн байгууллага		
2	Бизнесийн байгууллага		
3	Төрийн бус байгууллага		
4	Бусад		
	Нийт:		


2.2. Орон нутгийн байгууллагын хэрэглэгчийн мэдээлэл

№	Орон нутгийн хэрэглэгчийн төрөл	Тоо	Гэрээт хурдны хэмжээ нийт (Mbps)
0	1	2	3
1	Төрийн байгууллага		
2	Бизнесийн байгууллага		
3	Төрийн бус байгууллага		
4	Бусад		
	Нийт:		

2.3. Байгууллагын хэрэглэгчид санал болгож буй үйлчилгээний мэдээлэл

Үйлчилгээний төрлийг 2-р баганад сонгон тэмдэглэж, үйлчилгээний онцлох нөхцлийн талаар 3-р баганад бичнэ үү.

№	Үйлчилгээний нэр	<input checked="" type="checkbox"/>	Үйлчилгээний онцлох нөхцөл, тайлбар
0	1	2	3



1	Зохицуулалттай интернэт (managed internet)		
2	Дотоод сүлжээ (Wi-Fi зохион байгуулах гм)		
3	Дата төвд сервер байршуулах, сервер түрээслэх, хостинг гм		
4	Сервер зохион байгуулах (Data storage, data retrieve үйлчилгээ)		
5	И-мэйл үйлчилгээ		
6	Вэб хуудас байршуулах		
7	Домэйн нэр		
8	Цахим худалдаа		
9	Шууд урсгалд холбох (direct peering)		
10	Тоглоомын серверт холбох		
11	Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ		
12	Video streaming үйлчилгээ		
13	Байгууллагын салбар хоорондын холболт (VPN)		
14	Cloud үйлчилгээ		
15	IoT/M2M/BMS үйлчилгээ		
16	Бусад ... (нэрийг нь бичнэ үү)		
...			


**Жич:** Бусад үйлчилгээг нэмэхдээ өөр тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлдэг үйлчилгээг оруулахгүй.

**Нэмэлт үйлчилгээг үзүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудал байвал дурдана уу.**

#### 2.4. Байгууллагад үзүүлж буй үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Байгууллагад үзүүлж буй интернэт үйлчилгээг гэрээний хурдаар ангилан тухайн хурдаар үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо, хэрэглэгчид гэрээгээр дата лимит тогтоосон бол хэмжээг дурдаж, тэдгээр хэрэглэгчдээс нэмэлт үйлчилгээ авч байгаа бол харгалзах нэмэлт үйлчилгээ тус бүрд хэрэглэгчийн тоог оруулна. Хэрэглэгчийн тоог 2024 оны хагас жилийн байдлаар тооцно.

№	Интернэтийн урсгал	Хэрэглэгчийн тоо	Дата лимит (GB, Volume)	Нэмэлт үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо (нэмэлт үйлчилгээг 2.3-ын дагуу багана нэмж оруулна)		
				Зохицуулалттай интернэт	Дотоод сүлжээ	...
1	.... mbps					
2	.... mbps					
3	.... mbps					
4						
Нийт хэрэглэгчийн тоо						



### 3. Хэрэглэгчийн мэдээлэл

Энэхүү судалгааны хүрээнд аж ахуйн нэгж байгууллагын харилцаа холбоо, интернэтийн үйлчилгээний хэрэглээ, хэрэгцээ шаардлагыг судлах, тэдгээр хэрэглэгчдээс мөн судалгаа авах зорилготойгоор хэрэглэгчийн мэдээллийг дэлгэрүүлэн авч байгаа болно. Хэрэглэгчийн судалгаанд та бүхнийг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг хүсье.

Бид судалгааны мэдээллийг тайланд зөвхөн нэгтгэсэн мэдээлэл хэлбэрээр ашиглах ба тухайлсан компанийн нэрийг дурдахгүй болно.

#### 3.1. Улаанбаатар хотын байгууллагын хэрэглэгчдээс хамгийн өндөр гэрээний дүн (төлбөр төлдөг) бүхий 20 хэрэглэгчийн мэдээллийг оруулна уу.

№	Улаанбаатар хотын хэрэглэгчийн нэр	Хэрэглэгчийн төрөл: (Төрийн, бизнесийн, ТББ, бусад)	Гэрээний урсгалын хэмжээ, M bps	Дата лимит (GB, Volume)	Авч буй нэмэлт үйлчилгээг тэмдэглэх*			Интернэт урсгалтай холбоотой гэрээний нөхцөл
					Зохицуулалттай интернэт	Дотоод сүлжээ	...	
1								
2								
3								
4								

\*2.3-д тодорхойлсон үйлчилгээнүүдээс гэрээнд туссан үйлчилгээнүүдийг багана нэмж оруулан тэмдэглэнэ

#### 3.2. Орон нутгийн байгууллагын хэрэглэгчээс хамгийн өндөр гэрээний дүн (төлбөр төлдөг) бүхий 20 хэрэглэгчийн мэдээллийг оруулна уу.

№	Орон нутгийн хэрэглэгчийн нэр	Хэрэглэгчийн төрөл: (Төрийн, бизнесийн, ТББ, бусад)	Гэрээний урсгалын хэмжээ, M bps	Дата лимит (GB, Volume)	Авч буй нэмэлт үйлчилгээг тэмдэглэх*			Интернэт урсгалтай холбоотой гэрээний нөхцөл
					Зохицуулалттай интернэт	Дотоод сүлжээ	...	
1								
2								
3								
4								

\*2.3-д тодорхойлсон үйлчилгээнүүдээс гэрээнд туссан үйлчилгээнүүдийг багана нэмж оруулан тэмдэглэнэ


### 4. Нэмэлт асуулт болон мэдээлэл

4.1. Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернэтийн үйлчилгээнд тавьж буй нөхцөл, шаардлагууд нь танай үйл ажиллагаанд нийцэж байгаа юу?  
*Дараах хариултаас сонгож дугуйлан, холбогдох тайлбарыг бичнэ үү.*

4.1.1. Мөрдөж ажиллахад хүндрэлтэй биш, хэрэгжүүлэхэд боломжийн

4.1.2. Сайжруулах шаардлагатай.

Сайжруулах шаардлагатай гэж үзэж байвал яг ямар зохицуулалтыг нь тухайлбал ямар заалтыг нь сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа талаар дэлгэрэнгүй саналаа бичнэ үү.



**4.1.3.** Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Манай эрхэлж буй үйл ажиллагаанд тохирохгүй байгаа.  
Хэрэв хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзэж байвал хэрхэн сайжруулах талаар дэлгэрэнгүй саналаа бичнэ үү.

4.2. Байгууллагын хэрэглэгчийн хувьд нэмэлт үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгохтой холбоотой зөвшөөрлийн болон зохицуулалтын баримт бичигт шаардлагатай санал байвал дурдана уу.

4.3. Байгууллагын хэрэглэгчийн гэрээний загварыг хавсарган ирүүлнэ үү.

**5. Холбоо барих, харилцах мэдээлэл**

Энэхүү судалгаатай холбоотойгоор харилцах ажилтны мэдээлэл

Овог, нэр	
Албан тушаал	
Утасны дугаар	
И-мэйл хаяг	

**Судалгааны асуулгыг хавсралтаар хүргүүлсэн эксел файл дээр бөглөнө.**


~~oOo~~

**“БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТ (CORPORATE) ХЭРЭГЛЭГЧИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА”**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2025 он хүртэлх дунд хугацааны стратеги зорилгуудыг “Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах тэгш, хүртээмжтэй харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ”, “Харилцаа холбооны салбарт өрсөлдөөн, инновацийг дэмжин, хөгжлийг эрчимжүүлж, цахим үйлчилгээ хөгжих орчин болон харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.” гэж тодорхойлсон. Энэхүү зорилтын хүрээнд цахим үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, дижитал шилжилт, дижитал эдийн засгийг дэмжихэд төрийн болон бизнесийн бүх төрлийн байгууллагуудын интернэт холболт, хэрэглээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний боломж нөхцөл уян хатан байхад зохицуулалтыг чиглүүлэх зорилгоор энэхүү судалгааг авч байна.

Та бүхэн өөрийн байгууллагын интернэтийн хэрэглээ, үйлчилгээний нөхцөл байдлын талаарх дараах асуултад хариулна уу. Судалгаанд оролцсонд талархал илэрхийлье.





### **Байгууллагын мэдээлэл**

1. Танай байгууллагын үйл ажиллагааны чиглэл:
2. Ажилчдын тоо:
3. Байгууллага дээрхи интернэтийн гол хэрэглээ юу вэ?
  - 3.1. Оффис хэрэглээ
  - 3.2. Хэрэглэгчийн үйлчилгээнд
  - 3.3. Камер, дохиолол зэрэг хяналтын зорилгоор
  - 3.4. Өөрийн дэд бүтэц, программыг ажиллуулахад
  - 3.5. ...

*интернэтийг ямар зорилгоор юунд ашиглаж байгаа талаар мэдээлэл жиш, Оффист, үйлчилгээний салбаруудад хэрэглэгчдэд, хяналт шалгалт камер дохиолол, өөрийн дэд бүтэц програм зэрэг.*

4. Интернэт, сүлжээний үйлчилгээг хариуцдаг тусдаа алба, хэлтэстэй эсэх

### **Интернэтийн үйлчилгээний мэдээлэл**

5. Интернэт үйлчилгээ авч эхлээд хэдэн жил болж байгаа вэ?
6. Ямар ISP компаниас интернэтийн үйлчилгээ авдаг вэ?
7. Хэдэн жил тус үйлчилгээ эрхлэгчээс үйлчилгээ авч байгаа вэ?
8. Үйлчилгээ эрхлэгчийг сонгох болсон шалтгаан, гол хүчин зүйл юу вэ?
9. Танай байгууллагын байршилд интернэт оруулах сүлжээний дэд бүтэц, сувагчлал бэлэн байсан уу? Сүлжээ, дэд бүтцийг байгуулахад та бүхний оролцоо байсан уу?
10. Үйлчилгээний нөхцлөө сайжруулах арга хэмжээг хэрхэн авдаг вэ?
11. Өнгөрсөн хугацаанд ямар төрлийн үйлчилгээнүүдийг шинээр авч байсан тухай (Үндсэн интернэтийн үйлчилгээнээс гадна ямар нэмэлт үйлчилгээнүүд авдаг вэ? Нэмэлт урамшууллууд байдаг уу? )
12. Интернэтийн үйлчилгээндээ сэтгэл ханамж хэр байгаа вэ? 1-10 оноогоор үнэлбэл та хэдэн оноо өгөх вэ?
13. Интернэтийн үйлчилгээ эрхлэгчээ солих бодол байгаа эсэх?
14. Хэрэв тийм бол одоо байгаа үйлчилгээнээс танд юу нь илүү таалагдсан, солих талаар бодол төрүүлсэн бэ?
15. Танай байгууллага интернэт, дотоод сүлжээний үйлчилгээг хариуцдаг тусдаа алба хэлтэстэй эсэх? Гарсан гэмтэл саатлыг өөрсдөө шийдвэрлэдэг үү? Эсхүл байнгын тусламжийг интернэтийн үйлчилгээ эрхлэгчээсээ авдаг уу?
16. Интернэтийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт санал, хүсэлт байгаа юу?

~~~oOo~~~

